# Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ

P152343: МОНГОЛ УЛС – ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХОЁРДУГААР ТӨСӨЛ
2017 оны 1 дүгээр сар

1. УДИРТГАЛ....................................................................................................................1

2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ....................................................................................................1

3. ДЭЛХИЙН БАНКНЫ ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ ҮҮСЭХ.....................3

4. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨ..........................................................4

5. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ..............................5

6. ДЭД ТӨСЛИЙН ХАМГААЛЛЫН ХЭРЭГСЛИЙГ БЭЛТГЭХ, ХЯНАХ, БАТЛАХ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ ..................................................................................................................7

7. ЧАДАВХ ХӨГЖҮҮЛЭЛТ ......................................................................................................15

8. ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦОО ..................................................................................15

9. БОНУХ-НИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ............................................17

ХАВСРАЛТ А-1: ХАМГААЛЛЫН ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮСНЭГТ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1 19

ХАВСРАЛТ А-2: ХАМГААЛЛЫН ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮСНЭГТ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2 20

ХАВСРАЛТ Б-1: БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЖУРАМ (БОСНБЖ) .....22

ХАВСРАЛТ Б-2:НАРНЫ ФОТОВОЛЬТИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ БАЙГУУЛГАМЖИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ*НӨЛӨӨЛӨЛ БАГАСГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ*............................48

ХАВСРАЛТ В НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХҮРЭЭ .......................................................62

ХАВСРАЛТ Г 1: БОНУХ-НИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН МЭДЭЭЛЭЛ-Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ) 84

ХАВСРАЛТ Г-2: БОНУХ-НИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН МЭДЭЭЛЭЛ-Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц) 90

# 1. УДИРТГАЛ

Энэхүү Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-ний баримт бичиг нь Эрчим хүчний яамны дэргэдэх Төслийн удирдах нэгж (ТУН) болон Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ (БЗӨБЦТС) болон Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ (ЭБЦТС) цахилгаан түгээлтийн компаниудын төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) мөн Баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС)-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийг Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлогод нийцүүлэн хамгааллын зохих арга хэмжээг авахад чиглүүлэх зорилгоор боловсруулагдсан. Дэлхийн Банкны Эрчим хүчний салбарын хоёрдугаар төсөл (Төсөл) нь зээл батлагдахаас өмнө бүрэн тодорхойлогдсон хөрөнгө оруулалт болон зээл баталсны дараагаар тодорхойлогдох хөрөнгө оруулалт гэсэн бүтэцтэй. Энэхүү БОНУХ нь ***зээл батлагдсаны дараагаар тодорхойлогдсон*** Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд төслийн бүх хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа (доорх 2.2 хэсгийг үзнэ үү)-нд БЗӨБЦТС, ЭБЦТС компаниуд болон ББЭХС хүлээсэн хамгааллын үүрэг хариуцлагаа гүйцэтгэхэд чиглүүлэх зорилгоор боловсруулагдсан .

# 2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 2.1 Зорилго

Төслийн зорилго нь: сонгогдсон бүсийн цахилгаан түгээх компаниудын тогтвортой бөгөөд найдвартай цахилгааны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, Монгол Улсын эрчим хүчний салбарын зохицуулалтын чадавхийг сайжруулахад оршино. Түүнчлэн, санал болгож буй ТХЗ-ын түвшний үзүүлэлтэнд дараах орно*:* (i) цахилгаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх; (ii) түгээлтийн гэмтлээс шалтгаалсан шугамны тасалдлын давтамжийг бууруулах; (iii) төслийн хүрээнд байгуулсан сэргээгдэх эрчим хүч үүсгэх чадавх; (iv) хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцоолж буй бууруулалт; ба (v) тарифийн бодлогын зөвлөмжүүдийг хэвлүүлэх.

## 2.2 Бүрэлдэхүүн хэсэг

Тус төсөл нь дор дурдсан гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

Бүрэлдэхүүн хэсэг 1. “Түгээх сүлжээний шинэчлэл”. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь цахилгаан эрчим хүчний дэд бүтцийг бэхжүүлэн, цахилгаан түгээх сүлжээний сонгогдсон хэсгүүд дэх шугамын алдагдлыг бууруулах болон цахилгааны үйлчилгээний найдвартай байдал, хүртээмжийг сайжруулахад оршино. Тус бүрэлдэхүүн хэсэг нь дараах гурван дэд бүрэлдэхүүн хэсэгтэй байна: (i) БЗӨБЦТС-ний шинэчлэл ба өргөтгөл; (ii) ЭБЦТС-ний өргөтгөл ба шинэчлэл; (iii) Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (ЦДҮС)-ний хуваарилах байгууламжийн шинэчлэл.

Бүрэлдэхүүн хэсэг 2. “Нарны цахилгаан станц” нь Монгол Улсын СЭХНХ-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хүрээнд тодорхойлогдсоны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем дотор 10 МВт нарны PV цахилгаан станц барих ажлыг санхүүжүүлнэ. Түүнчлэн, тус Төслийн хүрээнд зээл батлагдсны дараагаар болон боломжит санхүүжилтээс хамааран нэмэлт нарны PV цахилгаан станцуудыг барих ажлыг санхүүжүүлж болзошгүй юм. Улмаар энэхүү БОНУХ-г засгийн газар болон Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн зохицуулалт, бодлого, журмыг хангахад хамгааллын нэмэлт журам, баримтжуулалтын чиглэлээр удирдамж өгөх зорилгоор боловсруулав.

Бүрэлдэхүүн хэсэг 3. “Чадавх бэхжүүлэлт”-энд төслийн менежмент, техникийн туслалцаа ба зорицуулалтын асуудлуудыг багтаасан сургалтууд орно. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь Эрчим хүчний яамны дэргэдэх төслийн удирдлагын нэгж (ТУН) болон бүсийн цахилгаан түгээх компаниуд болон ББЭХС-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-үүдийн чадавхийг техникийн туслалцаа, сургалт, танилцах

аялалаар дамжуулан бэхжүүлнэ. Тус бүрэлдэхүүн хэсэгт дараах хамаарна: (i) төслийн хэрэгжилт болон тусгай судалгаанд зориулсан техникийн туслалцаа; (ii) төслийн менежментийн чадавхийг сайжруулах сургалтын хөтөлбөрүүд; ба (iii) төслийн менежментийн зардал.

## 2.3 Зорилтот бүс

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
БЗӨБЦТС нь Улаанбаатар хотын ойролцоох Багануур дүүрэг болон 7 аймгийн (дүүрэг) 56 сум (тосгон)-ын нийт 46,568 хэрэглэгчид цахилгаан түгээн, нийлүүлдэг. Хэрэглэгчдийн дийлэнх хувийг оршин суугаа өрхүүд, багахан хувийг ЖДҮ, уурхайнууд эзэлдэг байна. ЭБЦТС нь 11 аймгийн 108 сумд тархсан 65,400 хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлдэг байна. Хэрэглэгчдийн олонх нь орлоготой багатай иргэд түлхүү оршин суудаг гэр хороололд амьдардаг.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Тодорхой байршил хараахан тогтоогдоогүй байна. Гэсэн хэдий ч тус Төслийн хүрээнд санхүүжигдэх нарны эрчим хүчний байгууламжуудыг Монгол Улсын баруун бүс (тухайлбал, Ховд болон Увс аймгуудад)-т байршуулахаар ЭХЯ-наас Дэлхийн Банктай тохиролцон, шийдвэрлэсэн болно. Ямарваа байгууламжийн байршлыг харгалзан үзэхдээ тухайлбал: (a) Монголын цахилгаан шугам сүлжээтэй ойртон холбогдох боломжтой (b) төрийн эзэмшлийн газар дээр байх мөн (c) усны эх үүсвэр ойролцоо байрлах боломжтой байхаар байрлуулах магадлалтай юм. Байршлууд нь Казак ба Цаатан үндэсний цөөнх иргэд амьдардаг Баян-Өлгий аймаг болон Хөвсгөл аймгийн хойд хэсэгт хамаарахгүй болно. Мөн Уйгур, Үзбек, Урианхай, Хотон (Тува/Цаатан) иргэд, Тунгус хэлээр ярьдаг Эвэнкчүүдийн амьдардаг газрууд хамрагдахгүй болно.

## 2.4 Урьдчилан хүлээгдэж буй дэд төслийн төрлүүд

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
БЗӨБЦТС болон ЭБЦТС-нээс энэхүү БОНУХ-г ашиглах дэд төслүүд нь Дэлхийн Банкны удирдлагын зөвлөлөөр төслийг бүхэлд нь батлуулахын өмнө тодорхойлогдсон дэд төслүүдтэй ерөнхийдөө адил болно. Тухайлбал дараах дэд төслийн төрлийг урьдчилан хүлээж байна:

- 6-10/0.4 кв трансформаторыг солих: хуучин трансформаторыг солих ба шинэ трансформаторыг суурилуулах
- 35/6-10 кв трансформаторын шинэ дэд станц барих
- Тосон хэлхээ салгуурыг шинэ вакуум хэлхээ салгуураар солих
- Вакуум хэлхээ салгуур суурилуулах
- Хуучин тоолуурыг солих ба шинэ тоолуур суурилуулах
- Цахилгаан түгээх шинэ шугам суурилуулах
- Хуучин модон тулгуур болон түгээх шугамны кабелийг солих

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Энэхүү Төслийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үзэх дэд төслийн төрөл нь зөвхөн нарны фотовольтийн эрчим хүч үйлдвэрлэх байгууламж байх юм.

Энэхүү БОНУХ-ний үндсэн хэсэгт боломжит дэд төслүүдийн хамгааллын үнэлгээний дараах асуудлууд орно:

- Дэд төслийн үндсэн шаардлагад нийцсэн байдал
- Эрсдлийн ерөнхий үнэлгээ ба ангилал (нөлөөллийн үнэлгээ)
- Хамгааллын баримт бичгийг боловсруулах
    - Байгаль орчны

- Нийгмийн
- Хэлэлцүүлэг
- Хууль тогтоомж/гэрээгээр хүлээх үүргүүд (нөхцөл)
- Хянах, батлах ба олон нийтэд мэдээлэх
- Хэрэгжүүлэх зохион байгуулалт ба үүрэг хариуцлага
    - Хяналт тавих
    - Тайлагнах
- Чадавх хөгжүүлэлт
    - Сургалт

## 3. ДЭЛХИЙН БАНКНЫ ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ ҮҮСЭХ

- Үйл ажиллагааны бодлого 4.01: Байгаль орчны үнэлгээ[1]

Тус төсөл нь хүн, машин ба эд материалын хөдөлгөөнтэй холбоотойгоор байгаль орчин, нийгмийн бага хэмжээний зарим сөрөг нөлөө (жишээлбэл шороо тоос, дуу чимээ, моторын утаа шэх мэт)-г үүсгэж болзошгүй тул энэхүү ҮБА 4.01-г хэрэгжүүлэх нөхцөл үүссэн. Төслийн хүрээнд хэд хэдэн транформаторын дэд станц буюу бусад цахилгааны тоног төхөөрөмжийг сэргээн засах ба/буюу солих ба тэдгээрийн зарим нь полихлорт бифенил (ПБФ) болон/эсвэл асбест агуулах буюу бохирдсон байж болзошгүй юм.

- Соёлын өв хөрөнгө

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд хамгийн их хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь одоо байгаа тоног төхөөрөмж (дэд станц, АШ-ыг дэмжих байгууламж-модон тулгуур гэх мэт)-ийг сэргээн засах буюу солих үйл ажиллагаа байх учир тус төсөл нь археологийн, палеонтологийн, түүхийн, шашны, гоо зүйн эсвэл соёлын бусад ач холбогдол бүхий хөдлөх буюу үл хөдлөх объект, газар, байгууламж, хэсэг байгууламжууд эсвэл байгалийн онцлог шинж буюу тогтоц зэрэг соёлын өв хөрөнгөд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж тооцоолж байна. Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хүрээнд байршил тодорхойлох шалгуур ба үндсэн шаардлага нь соёлын ач холбогдол бүхий ямарваа байршил/байгууламж дотор буюу дэргэд байрлах ямарваа байршлаас татгалзана. Гэсэн хэдий ч газар цэвэрлэх ба малтлага хийх үйл ажиллагаа явагдах магадлалтай тул гэнэтийн буюу “санамсаргүй олдворын” тохиолдол гарах боломжтой юм.

- Байгалийн амьдрах орчин

Энэхүү төсөл нь байгалийн амьдрах орчинг өөрчлөх үйл явцийг дэмжихгүй буюу уг үйл явцад хүргэхгүй гэж тооцоолж байна. Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд хамгийн их хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь одоо байгаа тоног төхөөрөмж (дэд станц, АШ-ыг дэмжих байгууламж-модон тулгуур гэх мэт)-ийг сэргээн засах буюу солих үйл ажиллагаа байна. Одоо ашиглагдаж буй дэд станцийг өргөтгөх эсвэл шинэ дэд станц барихад зарим хөрөнгө оруулалт хийгдэж магадгүй юм. Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хүрээнд байршил тодорхойлох шалгуур ба үндсэн шаардлага нь экологийн өндөр ач холбогдол бүхий эсвэл байгалийн зэрлэг амьтдын нүүдлийн маршрутад нөлөөлөх ямарваа байршил дотор буюу дэргэд байрлах байршлаас татгалзана.

- ҮАБ/ББ 4.10 Нутгийн уугуул иргэд

---

[1] *Дэлхийн Банкны зөвлөмж, бодлогын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг тус байгууллагын цахим хуудаснаас үзнэ үү:* http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/PROJECTS/EXTPOLICIES/EXTSAFEPOL/0,,menuPK:584441~pagePK:64168427~piPK:64168435~theSitePK:584435,00.html and http://www.ifc.org/ifcext/sustainability.nsf/Content/EHSGuidelines

Монгол Улсад нүүдэлчин овгуудаас гарал үүсэлтэй 24 ястан байдаг гэж үздэг. Эдгээрийн ихэнх нь Халх ястан бөгөөд хүн амын 90 хувийг эзэлдэг. Монгол Улсын баруун хэсэгт оршин суудаг Казах цөөнхийг эс тооцвол бүх ястангууд Монгол хэлээр ярьдаг ба энэ нь Халх аялгуугаар ярьдаг хүмүүст ойлгомжтой байдаг. Зөвхөн Казак иргэд бусдаас өөр хэлээр ярьдаг. Монгол Улсын цөөнх ястангуудын дийлэнх нь Халх ястантай ижил зан заншил, уламжлал болон үйлдвэрлэлийн тогтолцоотой. Монголын баруун хэсэгт амьдардаг, зонхилон Исламын шашинтай бөгөөд хэл зүйн хувьд ялгаатай Казах иргэд болон тус улсын хойд хэсэгт амьдардаг, уламжлалт, нүүдэлчин, цаа буга малладаг Цаатан иргэдийг эс тооцвол Монгол ястангуудыг тус төсөлд оролцох боломжийг нь ямар нэгэн байдлаар хязгаарлах эдийн засаг, нийгэм эсвэл эрх зүйн хувьд орхигдсон буюу өөрөөр хэлбэл таагүй нөхцөл байдалд байдаг гэж үздэггүй болно. Бүрэлдэхүүн хэсэг 1 ба 2-ын аль алинд Казак (алс баруун хязгаарын аймаг) эсвэл Цаатан (Хөвсгөл аймгийн хойд хэсэг) цөөнхүүдийн аль алины оршин суудаг газрууд хамрагдахгүйгээс гадна Уйгур, Үзбек, Урианхай, Хотон (Тува/Цаатан) иргэд, Тунгус хэлээр ярьдаг Эвэнкчүүдийн амьдардаг газрууд хамрагдахгүй учир уугуул иргэдийн талаарх баримтлах ҮАБ/ББ 4.10-ыг хэрэгжүүлэх нөхцөл байдал үүсэхгүй болно.

- ҮАБ/ББ 4.12 Албадан нүүлгэн шилжүүлэлт

Энэхүү төслийн хүрээнд барилгын ажлаас шалтгаалан ямар нэгэн газар албадан чөлөөлөлт, өрх эсвэл бизнесийн аж ахуйн нэгжийн нүүлгэн шилжүүлэлт явагдахгүй гэж тооцоолж байна. Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээн дэх бүх ажлыг одоо ашиглагдаж буй цахилгаан түгээх дэд бүтцэд, төрийн эзэмшлийн газар дээр эсвэл одоо хэрэгжиж буй дамжин өнгөрөх эрхийн хүрээнд гүйцэтгэнэ гэж урьдчилан тооцоолж байна. Гэсэн хэдий ч бага хэмжээний ажилд зориулан хэлэлцсэн тохиролцоо эсвэл сайн дурын хандиваар дамжуулан газар худалдан авах ёстой болох тохиолдолд гарч болзошгүй юм. Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хүрээнд ирээдүйд ашиглах ямарваа байршил нь албан ба албан бус байдлаар ашиглагдаагүй төрийн эзэмшлийн газар дээр байна гэж тооцоолж байна. Бүрэлдэхүүн хэсэг 1 ба 2-ын аль алины ямар нэгэн байршил болон хүн амд үзүүлж болзошгүй нөлөөллийг хараахан эцэслэн тодорхойлоогүй байгаа тул Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ (НШБХ) баримт бичгийг бэлтгэн, энэхүү БОНУХ баримт бичигт хавсаргав (Хавсралт В-г үзнэ үү). НШБХ баримт бичигт төслийн үйл ажиллагаанд (бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд) зориулан ямар нэгэн газрыг албадан чөлөөлөх, хэлэлцсэн тохиролцоогоор дамжуулан худалдан авах эсхүл сайн дураар хандивлахад авах арга хэмжээг авч үзсэн болно.

## 4. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨ

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*

Төслийг үнэлэх шатанд дэд төслүүдийн нарийвчилсан төрөл болон байршил тодорхой бус байх учир дэд төслүүдтэй холбогдон үүсэж болзошгүй тодорхой нөлөөллүүд их хэмжээтэй байх магадлал байхгүй ба үнэн хэрэгтээ тогтоогдоогүй байна. Өмнөх туршлагад тулгуурлан, асуудал үүсгэж магадгүй гэж урьдчилан тооцоолж буй ерөнхий нөлөөлөлд дэд төслийн барилга угсралтын ажлын үеэрх ажилчдын аюулгүй ажиллагааны асуудлууд, аюултай (ПБФ) хог хаягдлын зохицуулалт, аюултай бус хог хаягдал зайлуулалт болон тоосжилт, дуу чимээ үүсэх орж болзошгүй. Ихэнх тохиолдолд болзошгүй нөлөөллийг хязгаарлахаар урьдчилан тооцоолж байгаа ба эдгээр нөлөөлөл нь хязгаарлагдмал хугацаатай, хуучин байдалдаа эргэн орох боломжтойгоос гадна төслийн барилга угсралтын явцад зохих төлөвлөлт, сайн менежментийн үйл ажиллагаагаар дамжуулан түргэн зохицуулагдах боломжтой юм.

Бүрэлдэхүүн хэсэг 1 нь өнөөгийн байдалд эрчим хүчээр хязгаарлагдаад буй нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна. Байгууллагын, аж үйлдвэрийн, бизнесийн болон ахуйн зэрэг цахилгаан эрчим хүчний

бүх хэрэглэгчид төсөл хэрэгжихгүй байхтай харьцуулахад илүү найдвартай эрчим хүчний хангамжийн үр ашгийг эцсийн үр дүнд хүртэнэ. Түүнчлэн, тус төсөл нь одоогоор үйлчилгээ хүрдэггүй бичил, жижиг болон дунд бизнесүүдийг цахилгаан эрчим хүчтэй болгоно. Нэн ялангуяа эмэгтэйчүүд ба хүүхдүүд орчин үеийн боловсрол, эрүүл мэнд ба харилцаа холбооны үйлчилгээ авах, ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх мөн айл өрхүүдэд тустай орлого олох бага хэмжээний үйл ажиллагаанд дөхөм болоход нэн чухал байдаг цахилгаан хангамжийн үйлчилгээний сайжралтаас үр шимийг хүртэнэ. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн болзошгүй сөрөг нөлөөллийг Хавсралт В, Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд авч үзэв.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Төслийг үнэлэх шатанд дэд төслүүдийн нарийвчилсан төрөл болон байршил тодорхой бус байх учир энэхүү бүрэлдэхүүн хэсгийн дэд төслүүдтэй холбогдон үүсэж болзошгүй тодорхой нөлөөллүүд тогтоогдоогүй байна. Өмнөх туршлагад тулгуурлан, асуудал үүсгэж магадгүй гэж урьдчилан тооцоолж буй ерөнхий нөлөөлөлд ажилчдын аюулгүй ажиллагааны асуудлууд, дэд төслийн барилга угсралтын ажлын үеэрх аюултай хог хаягдлын зохицуулалт ба аюултай бус хог хаягдал зайлуулалт болон тоосжилт, дуу чимээ үүсэх асуудлууд, замын хөдөлгөөний хэлбэр алдагдалт орж болзошгүй. Ихэнх тохиолдолд болзошгүй нөлөөллийг хязгаарлахаар урьдчилан тооцоолж байгаа ба эдгээр нөлөөлөл нь хязгаарлагдмал хугацаатай, хуучин байдалдаа эргэн орох боломжтойгоос гадна төслийн барилга угсралтын явцад зохих төлөвлөлт, сайн менежментийн үйл ажиллагаагаар дамжуулан түргэн зохицуулагдах боломжтой юм.

Тооцоологдож буй нийгмийн нөлөөлөл нь богино хугацааны хөдөлмөр эрхлэх мөн орон нутгаас ханган нийлүүлэх боломжтой холбоотойгоор голдуу эерэг байна. Энэхүү бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой үүсэх нөлөөллийн түр зуурын байдлыг харгалзан шилжин ирэх орон нутгийн бус барилга угсралтын ажилчдын тоо бага (200 хүнээс бага) байхаар тооцоолж байна. Тус хөрөнгө оруулалтын хамрах хүрээнд цахилгаан хангамжийн үйлчилгээнд ямар нэгэн хэрэглэгчийг шинээр холбохгүй гэж тооцоолж байгаагаас гадна цаашдын хөрөнгө оруулалтын үр дүнд шинэ холболт бий болохгүй гэж тооцоолж байна. Одоогийн нөхцөлд Орос улсаас байнгын бөгөөд найдвартай цахилгаан хангамжийг авч ашигладаг мөн хэрэглэгчид (төв суурин газруудад) аль хэдийн уг үйлчилгээнд холбогдсон байгаа тул цахилгаан хэрэглэгчийн үнэнд өөрчлөлт орох болон найдвартай байдал нэмэгдэх боломж зэрэг тооцоологдоогүй болно).

Байгаль орчин ба нийгмийн үнэлгээг 2016 оны 11 сард гүйцэтгэсэн. Орон нутгийн иргэдэд учруулах эерэг ба сөрөг үр дагаврын талаар лавшруулан ойлголттой болох мөн сөрөг үр дагаврыг багасгах арга хэмжээг санал болгох зорилгоор нийгмийн нөлөөлөлд үнэлгээ хийсэн. Ирээдүйд ашиглагдах байршлуудад төрийн эзэмшлийн газар ашиглах боломжгүй тохиолдолд үүсэх албадан нүүлгэн шилжүүлэлтийн болзошгүй сөрөг нөлөөллийг Хавсралт В, Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд авч үзэв.

## 5. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ

Дуу чимээ, тоосжилт, чичиргээ, хог хаягдал үүсэх, замын хөдөлгөөнд саад учруулах, олон нийтийн аюулгүй байдал гэх мэт нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах зорилгоор ихэнх барилга угсралтын төслүүдэд нийтлэг хэрэглэдэг ерөнхий цогц арга хэмжээгээр дамжуулан биет, биологийн болон нийгмийн орчин нөхцөлд үзүүлж болзошгүй нөлөөллийн дийлэнхийг багасгах боломжтой байдаг.

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх тодорхой шаардлагуудыг заасан Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах журам (БОСНБЖ)-ын багцийг урьдчилан тооцоолж буй дэд төслийн төрлүүдэд зориулан бэлтгэсэн болно. Эдгээр БОСНБЖ-г Хавсралт Б-1-т үзүүлэв.

БОСНБЖ-ын хамрах хүрээ, агуулгад дараах орно:

Хамрах хүрээ: Эдгээр БОСНБЖ-аар зохицуулагддаг бага хэмжээний ажлуудад зориулсан барилга угсралтын үйл ажиллагааны нөлөөлөл нь хязгаарлагдмал цар хүрээтэй, түр хугацааны бөгөөд хуучин байдалдаа эргэн орон боломжтойгоос гадна барилга угсралтын сайн дадлаар түргэн шийдвэрлэгддэг.

Дараах асуудлуудад зориулсан сөрөг нөлөөллийг бууруулахаар авах нийтлэг арга хэмжээг тодорхойлсон:

- Тоосжилт үүсэх
- Дуу чимээ ба чичиргээ
- Усны бохирдол
- Ус зайлуулалтын систем ба тунадасжилт
- Хатуу хог хаягдал
- Химийн буюу аюултай хог хаягдал/эд материал
- Ургамлын хучилт ба экологийн нөөц баялагийг сүйтгэх
- Замын хөдөлгөөний зохицуулалт
- Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал
- Олон нийт ба ажилчдын аюулгүй байдал
- Орон нутгийн иргэдтэй харилцах
- Санамсаргүй олдворын журам

Өртөмхий газрууд (суурин газар, эмнэлэг, сургууль г.м), гадаргын ус (гол горхи, булан тохой, цөөрөм г.м)-ны ойролцоох байгууламж зэрэг барилга угсралтын явцад арга хэмжээ авах шаардлагатай болох тухайн ажлын талбарт хамаарах нөлөөллүүд гарч болзошгүй юм. Эдгээр арга хэмжээг тодорхойлох ба засгийн газрын холбогдох техникийн журмуудыг даган, БОСНБЖ-д нэмэлт арга хэмжээ болон нэгтгэнэ.

Нийгмийн нөлөөллүүдэд хамаатуулан зээлдэгч нь Банкны ажлын хэсэгтэй хамтран төсөлд зориулан нийгмийн үнэлгээг 2016 оны IV улиралд бэлтгэнэ. Үүнд үр шимийг хүртэх хүн амын талаарх мэдээллийн тоймыг гаргах ба дэд төслийн төлөвлөлтөнд оруулах нийгэм, эдийн засгийн мэдээлэл нэмэртэй юм. Дотоодын зөвлөхүүд ажлын хэсгийн гишүүдтэй хамтран төслийн үр ашиг, нийгмийн нөлөөлөл ба эрсдэл мөн шаардлагатай бууруулах арга хэмжээний баримт болох орон нутгийн нийгэм-эдийн засаг болон соёлын асуудлуудыг тодорхойлох зорилгоор анхдагч болон хоёрдогч мэдээллийг цуглуулна. Нийгмийн үнэлгээг бие даасан баримт бичиг болгон боловсруулсан.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Мянгад суманд байрлах эхний нарны цахилгаан станцийн төсөлд зориулан боловсруулсан БОННҮ (P 152343 МОНГОЛ УЛС Эрчим хүчний салбарын хоёрдугаар төсөл, Бүрэлдэхүүн хэсэг 2, БОННҮ [Нарны цахилгаан станц] 2016)-тэй цар хүрээний хувьд адил хязгаарлагдмал хэмжээний БОННҮ шаардлагатай болно. Тус БОННҮ-ний суурь болгон Хавсралт Б-2-т үзүүлсэн ерөнхий БОУТ-г ашиглаж болно.

Сөрөг нөлөөлөл багасгах нийтлэг арга хэмжээг дараах чиглэлээр тодорхойлов:

*Төлөвлөлт*

- *Экологийн хамгаалалт*

*Барилга угсралт*

- Нийгэм-эдийн засгийн нөлөөлөл (орон нутгийн иргэдийн тав тухыг алдагдуулан,төвөг учруулах, нийгмийн эрүүл мэнд ба аюулгүй байдал, шилжин ирэх ажилчид)
- Тоосжилт үүсэх

- Моторын утаа ялгаруулалт
- Дуу чимээ ба чичиргээ
- Гадаргын өөрчлөгдсөн урсац
- Хөрсний менежмент
- Ургамлын хог хаягдлын менежмент
- Хатуу хог хаягдал (аюултай ба аюулгүй)
- Хаягдал усны менежмент
- Ажилчдын аюулгүй байдал
- Санамсаргүй олдворын журам
- Шувууны болон хуурай газрын төрөл зүйлийн хамгаалалт

*Үйл ажиллагаа*

- Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт ба ханган нийлүүлэлтийн боломжууд
- Үзэгдэх орчин сарнилт
- Хавтан угаах усны менежмент
- Аюултай хаягдал
- Экологийн хамгаалалт

*Ашиглалтаас гаргах*

- Хог хаягдал зайлуулалт
- Газар сэргээх

Өртөмхий газрууд (суурин газар, эмнэлэг, сургууль г.м), гадаргын ус (гол горхи, булан тохой, цөөрөм г.м)-ны ойролцоох байгууламж зэрэг барилга угсралтын явцад арга хэмжээ авах шаардлагатай болох тухайн ажлын талбарт хамаарах нөлөөллүүд гарч болзошгүй юм. Эдгээр арга хэмжээг тодорхойлох ба засгийн газрын холбогдох техникийн журмуудыг даган, БОУТ-нд нэмэлт арга хэмжээ болон оруулна.

Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хувьд биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн аль алинтай холбоотой албадан нүүлгэн шилжүүлэлтийн ямарваа нөлөөлөл тооцоологдоогүй болно. Нарны эрчим хүчний станцтай холбоотой ямарваа сонгосон байршлуудад төрийн эзэмшлийн газрын ашиглалтыг нэн тэргүүд чухалчлана. Гэсэн хэдий ч нүүдэллэж амьдардаг өрхийн ашигладаг газар гэх мэтээр тухайн байршил нь айл өрхүүдэд нөлөөлөх тохиолдолд эдгээр асуудлыг НШБХ (Хавсралт В)-д дурдсны дагуу шийдвэрлэнэ.

Нийгмийн бусад нөлөөллүүд (орон нутгийн иргэдийн тав тухыг алдагдуулан,төвөг учруулах, нийгмийн эрүүл мэнд ба аюулгүй байдал, шилжин ирэх ажилчид)-тэй холбогдуулан үнэлгээ хийн, ерөнхий БОУТ-нд сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг оруулсныг Хавсралт А-гаас үзнэ үү. Нарны цахилгаан станцтай холбоотой цаашдын аливаа үйл ажиллагаанд орон нутгийн хүн ам зүй, боломжит үйлчилгээ мөн дэд бүтцийн мэдээллийн тоймыг агуулсан баримтжуулалттай байх шаардлагатай юм.

## 6. ДЭД ТӨСЛИЙН ХАМГААЛЛЫН ХЭРЭГСЛИЙГ БЭЛТГЭХ, ХЯНАХ, БАТЛАХ БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*

Төслийн хэрэгжилтийн үе шатанд БЗӨБЦТС ба ЭБЦТС нь нийгэм ба байгаль орчны хамгааллын шаардлагуудтай холбогдуулан төсөлд бүхэлд нь хяналт тавин, зохицуулах үүрэг, дадлага бүхий албан хаагчийг ажиллуулахаар томилсон. Хөрөнгө оруулалтын ихэнх нь харьцангуй бага хэмжээтэй учир, үр ашигтай байдлыг хангах үүднээс “дэд төсөл”-ийг худалдан авах ажиллагааны нэг багц болгон нэгтгэсэн хэд хэдэн хөрөнгө оруулалт байхаар тооцно.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*

Төслийн хэрэгжилтийн үе шатанд ББЭХС нь нийгэм ба байгаль орчны хамгааллын шаардлагуудтай холбогдуулан төсөлд бүхэлд нь хяналт тавин, зохицуулах үүрэг, дадлага бүхий албан хаагчийг ажиллуулахаар томилсон.

## 6.1 Дэд төслийн үндсэн шаардлагад нийцсэн байдал

### *Байгаль орчин, нийгмийн шаардлагуудтай холбоотой засгийн газрын зөвшөөрлүүд*

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
БЗӨБЦТС эсвэл ЭБЦТС нь Хавсралт А-1-д буй Хүснэгтийг бөглөх ба ингэхдээ Хүснэгтэд бичсэн зүйлсийн үндэслэлийг харуулсан ямарваа баримт бичиг (жишээ нь: зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, батласан албан тоот г.м.)-ийн хуулбарыг хамт хавсаргана. Бөглөсөн хүснэгт болон холбогдох баримт бичгийг Төслийн баримт бичигт оруулна.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
ББЭХС нь Хавсралт А-2-д буй Хүснэгтийг бөглөх ба ингэхдээ Хүснэгтэд бичсэн зүйлсийн үндэслэлийг харуулсан ямарваа баримт бичиг (жишээ нь: зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, батласан албан тоот г.м.)-ийн хуулбарыг хамт хавсаргана. Бөглөсөн хүснэгт болон холбогдох баримт бичгийг Төслийн баримт бичигт оруулна.

Эдгээр Хүснэгтүүд нь барилга угсралтын явцад мөрдөгдөх Монгол Улсын газар ашиглалт, байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй байдлын холбогдох хууль тогтоомж (БОҮ-г батлуулах, хог хаягдал зэрэгт зориулан зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг авах/авсан)-ийг баталгаажуулах зорилготой.

### *Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлт*

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
БЗӨБЦТС ба ЭБЦТС нь санал болгож буй дэд төслийн байршлыг нягтлаж үзнэ. Хавсралт В-гийн дагуу тухайн дэд төслийн санал болгож буй байршилд газар чөлөөлөлт ба/буюу нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа хамаарах бол тус компаниуд нь бусад дэд төслүүдэд зориулан газрын талаарх баримтлах үндсэн шаардлагад нийцсэн байдлын хяналтыг өмнө хийж байсан эсэхийг тодорхойлохын тулд ТУН-ээс лавлана. Хэрэв тухайн газарт зориулан үндсэн шаардлагад нийцсэн байдлын хяналтыг гүйцэтгэж байсан бол уг үйл ажиллагааг дахин давтах шаардлагагүй юм. Хэрэв үндсэн шаардлагад нийцэх байдлын ямар нэгэн хяналтыг өмнө хийж байгаагүй бол БЗӨБЦТС ба ЭБЦТС нь дэд төслийг үргэлжлүүлэн боловсруулахын тулд уг хяналтыг гүйцэтгэх үүргийн талаар ТУН-д мэдээлнэ. Үндсэн шаардлагад нийцсэн байдлын хяналтын үнэр бөглөх шалгах хуудсыг Хавсралт В15 хэсгээс үзнэ үү.

Хэрэв уг газар төрийн өмчийн газар бол үндсэн шаардлагад нийцэх байдлын арга хэмжээгээр тухайн газартай холбоотой ямар нэгэн зарга байхгүй ба/буюу тухайн газрын ямар нэгэн албан бус ашиглалт эсвэл газарт суурилсан хөрөнгө байхгүйг тодруулна.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
ТУН нь санал болгож буй дэд төслийн байршлыг нягтлаж үзэх ба тухайн газрын эзэмшлийн байдал (тухайлбал, төрийн эзэмшлийнх/бусад)-ыг тодорхойлох зорилгоор үндсэн шаардлагад нийцсэн байдлыг нягтлах үйл ажиллагааг зохион байгуулна. Ингэхдээ тухайн газарт хэн нэгэн албан эсвэл албан бусаар амьдарч эсвэл ашиглаж байгаа эсэх; мөн тухайн газартай холбоотой шийдвэрлэгдээгүй ямарваа гомдол, зарга бий эсэхийг нягтлана. Үндсэн шаардлагад нийцсэн байдлын хяналтын үеэр бөглөх шалгах хуудсыг Хавсралт В-гийн В14, Хэрэгсэл 7-оос  үзнэ үү.

Газар албадан чөлөөлөх шаардлагатай болох буюу тухайн газраас газар ашиглагчдыг нүүлгэн шилжүүлэх тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө шаардлагатай болно. Авах ёстой алхмуудыг Хавсралт В-гийн 6-р хэсэгт тоймлон үзүүлэв.

Хоёр бүрэлдэхүүн хэсгийн аль алины хувьд санал болгож буй дэд төсөлд зориулан газрын чөлөөт зах зээлийн худалдан авалт хийх шаардлагатай болвол Дэлхийн Банкнаас тус газар авах үйл ажиллагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу сайн дурын худалдан авагч болон худалдагч нарын хооронд болсон ба тухайн газартай холбоотой шийдвэрлэгдээгүй ямар нэгэн гомдол, өр төлбөр байхгүйг батлах баталгаа (тухайлбал баримт бичиг)-г шаардана: *нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны ямар нэгэн төлөвлөгөө шаардлагагүй болно.*

## 6.2 Ерөнхий үнэлгээ ба ангилал (Нөлөөллийн үнэлгээ)

Төслийн үнэлгээний өмнө тодорхойлогдсон бүх хөрөнгө оруулалтыг Дэлхийн Банкны Байгаль орчны үнэлгээний бодлого (ҮАБ 4.01)-ын дагуу "Б ангилал"-д хамааруулсан болно (доорхийг үзнэ үү). Удирдах зөвлөлөөр батлагдсны дараа тодорхойлогдох Бүрэлдэхүүн хэсэг 1 ба 2-ын хөрөнгө оруулалт нь ижил төрлийнх байх магадлал их учир Б ангилалд хамаарагдах магадлалтай. *Гэхдээ Удирдах зөвлөлөөр батлагдсны дараагаар <u>шинэ төрлийн хөрөнгө оруулалтыг</u> авч хэлэлцэхээр болвол БЗӨБЦТС ба ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) эсвэл ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) нь Дэлхийн Банкны ажлын хэсэгтэй зөвлөлдвөл зохих ба тус ажлын хэсэг нь байгаль орчин, нийгмийн хамгааллын мэргэжилтнүүд (Дэлхийн Банк- GSURR ба GENR)-тэй дээрх төрлийн ямарваа хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн өмнө дагах журам болон шаардагдах хамгааллын баримт бичгийн талаар зөвлөлдөнө.*

Дэлхийн Банкны Ерөнхий үнэлгээ/ангиллын тогтолцоо нь төслүүдийг төрөл, байршил, мэдрэмтгий байдал, цар хүрээ болон тэдгээрийн болзошгүй нөлөөллийн шинж чанар, хэмжээнээс хамааран А, Б, В гэж гурван ангиллын аль нэгт ангилдаг. Дэлхийн Банкны тогтолцооны дагуу ерөнхий үнэлгээний өөр өөр ангилалд хамаарах төслүүд нь дараах ерөнхий шинж чанартай байна::

***А ангилал:*** Санал болгож буй төсөл нь эмзэг, олон төрлийн эсвэл урьд өмнө тохиолдож байгаагүй байгаль орчны ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай бол А ангилалд ангилагддаг. Эдгээр нөлөөлөл нь биет үйл ажиллагаа явагдах байршил байгууламжаас өргөн хүрээтэй газар нутгийг хамрах нь бий. А ангиллын төслүүдэд зориулсан Дэлхийн Банкны бодлого, журмын тодорхой шаардлагад нийцсэн бүрэн хэмжээний БОНҮ шаардлагатай болно.

***Б ангилал:*** Санал болгож буй төслийн хүн ам эсвэл намагшсан газар, ой, бэлчээр болон байгалийн бусад амьдрах орчинг оролцуулан байгаль орчны хувьд чухал газарт үзүүлж болзошгүй байгаль орчны сөрөг нөлөөлөл нь А ангиллын төслөөс харьцангүй бага хор хөнөөлтэй бол Б ангилалд хамаарна. Эдгээр нөлөөлөл нь ажлын талбарт хамаарах нөлөөлөл байдаг; хуучин байдалдаа эргэн орох боломжгүй нөлөөлөл цөөн байдаг; ихэнх нөлөөлөл нь төслийн байршлаар гол төлөв хязгаарлагдсан байдаг ба ихэнх тохиолдолд бууруулах арга хэмжээг стандарт журмаар түргэн боловсруулах боломжтой байдаг. БОҮ-ний хамрах хүрээ нь А ангиллын БОҮ-нээс хамаагүй бага байдаг ба ихэнхдээ Байгаль орчны удирдлагын төлөвлөгөө (БОУТ) ба/буюу БОСНБЖ хангалттай байдаг.

***В ангилал:*** Санал болгож буй төсөл нь байгаль орчны ямар нэгэн сөрөг нөлөөлөл байхгүй эсвэл маш бага хэмжээнд байх магадлалтай бол В ангилалд ангилагддаг. Ерөнхий үнэлгээ хийхээс гадна ямар нэгэн БОҮ-ний арга хэмжээ эсвэл ямарваа байгаль орчны баримт бичиг шаардлагагүй.

## 6.3 Хамгааллын баримт бичгийг боловсруулах

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*

БЗӨБЦТС ба ЭБЦТС нь байгаль орчинтой холбоотой хамгааллын бүх баримт бичгийг бэлтгэх үүрэгтэй. ТУН нь нийгмийн хамгааллын бүх баримт бичгийг хариуцах ба эдгээр баримт бичгийг боловсруулахад БЗӨБЦТС ба ЭБЦТС-тэй хамтарч ажиллана.

*Байгаль орчин*

Байгаль орчны хувьд Дэлхийн Банкны төслийн хүрээнд зөвхөн Б ангиллын төсөлд дэмжлэг үзүүлнэ.

Дэд төслийн байгаль орчны асуудлууд нь зөвхөн барилга угсралтын үйл ажиллагаатай мөн магадгүй газар цэвэрлэхтэй холбоотой байгаа учир Хавсралт Б-1-т үзүүлсэн энгийн БОСНБЖ-ууд Дэлхийн Банкны байгаль орчны дэд төслүүдийн баримт бичигт тавих шаардлагуудыг хангахад хангалттай байна. БЗӨБЦТС ба ЭБЦТС нь Хавсралт Б-1-т үзүүлсэн ерөнхий БОСНБЖ-уудыг нягтлан үзэх ба тухайн дэд төсөлд үл хамаарах асуудал/эрсдэл болон холбогдох хор хөнөөл бууруулах арга хэмжээг устгана/хасна. Шинэчилсэн БОСНБЖ-ыг дэд төслийн БОҮ-ний баримт бичигт танилцуулна.

Оршин суух зориулалтын барилга байгууламж эсвэл бусад өртөмхий газар (жишээ нь: сургууль, эмнэлэг, асрамжийн газар г.м)-тай ойр байх, ажилчдын камп шаардлагатай болох зэрэг тухайн байршилд хамаарах асуудлууд гарч болзошгүй тохиолдолд БОСНБЖ-д нэмэлтээр оруулбал зохино.

*Нийгэм*

ТУН нь НШБХ (Хавсралт В-г үзнэ үү)-ний зарчмуудыг бататгах газар/амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийн ерөнхий үнэлгээг төслийн төлөвлөлтийн явцтай зэрэг гүйцэтгэснийг баталгаажуулах үүрэг бүхий хүмүүсийг татан оролцуулна.

Дэд төсөл тус бүрийн хувьд сайн дурын газар хандивлалт (зөвхөн Бүрэлдэхүүн хэсэг 1-т) боломжтой эсэх (Хавсралт В-г үзэх) эсвэл албадан Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд суурилсан Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ) буюу Нүүлгэн шилжүүлэлтийн товч төлөвлөгөө (НШТТ) шаардлагатай болох эсэхийг тодорхойлох зорилгоор газар эзэмшил, газарт тавигдах шаардлага болон газар суурилсан хөрөнгийг чөлөөлөх шаардлагын талаарх ерөнхий үнэлгээг гүйцэтгэнэ. Энэхүү баримт бичигт нүүлгэн шилжүүлэлтийн баримт бичгүүдийн алийг ч сонгосон товчлох зорилгоор “НШТ” гэдэг нэршлийг ашиглана. ТУН нь БЗӨБЦТС ба ЭБЦТС-тэй хамтран Нүүлгэн шилжүүлэлтийн ямарваа төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*

ТУН нь байгаль орчинтой холбоотой хамгааллын бүх баримт бичгийг бэлтгэх үүрэгтэй ба эдгээрийн ББЭХС-тэй хамтран бэлтгэнэ. ТУН нь нийгмийн хамгааллын бүх баримт бичгийг хариуцах ба эдгээр баримт бичгийг боловсруулахад ББЭХС-тэй хамтарч ажиллана.

*Байгаль орчин*

Байгаль орчны хувьд Дэлхийн Банкны төслийн хүрээнд зөвхөн Б ангиллын хөрөнгө оруулалтанд дэмжлэг үзүүлнэ.

Дэд төслийн байгаль орчны асуудлууд нь бага хэмжээний, хязгаарлагдмал хүрээг хамарсан бөгөөд төсөл дуусгавар болсны дараагаар ерөнхийдөө буцаан хэвийн байдалд орох боломжтой байгаа тул Мянгад суманд байрлах эхний нарны цахилгаан станцийн төсөлд зориулан боловсруулсан БОННҮ (P 152343 МОНГОЛ УЛС Эрчим хүчний салбарын хоёрдугаар төсөл, Бүрэлдэхүүн хэсэг 2, БОННҮ [Нарны цахилгаан станц] 2016)-тэй цар хүрээний хувьд адил хязгаарлагдмал хэмжээний БОННҮ шаардлагатай болно Тус БОННҮ-ний суурь болгон Хавсралт Б-2-т үзүүлсэн ерөнхий БОУТ-г Дэлхийн Банкны дэд төслүүдэд шаардагдах байгаль орчны баримт бичгийн салшгүй нэг нэсэг болгон ашиглаж болно. ББЭХС нь БОННҮ-г боловсруулахад Хавсралт Б-2-т үзүүлсэн ерөнхий БОУТ-г нягтлан үзэх ба ямарваа тухайлан санал болгож буй

нарны фотовольтийн эрчим хүчний байгууламжтай үл хамаарах асуудал/эрсдэл болон холбогдох хор хөнөөл бууруулах арга хэмжээг устгана/хасна. Шинэчилсэн БОУТ нь дэд төслийн БОННҮ-ний баримт бичгийн нэг хэсэг болно. Шувууны бүлгэмдлийн /avifauna/ үнэлгээ буюу тухайн орчны шувуудын үнэлгээ нь төслөөс нүүдлийн болон газарт үүрээ засдаг шувуудын төрөл зүйлд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоох, болзошгүй нөлөөллийг төслийн дизайн болон БОУТ-нд тооцон оруулах зорилгоор хязгаарлагдмал БОННҮ-ний нэг хэсэг болно.

Оршин суух зориулалтын барилга байгууламж эсвэл бусад өртөмхий газар (жишээ нь: сургууль, эмнэлэг, асрамжийн газар г.м)-тай ойр байх, ажилчдын камп шаардлагатай болох зэрэг тухайн байршилд хамаарах асуудлууд гарч болзошгүй тохиолдолд тухайн байршилд тусгайлан зориулсан БОУТ-нд нэмэлтээр оруулбал зохино.

*Нийгэм*

ТУН нь НШБХ (Хавсралт В-г үзнэ үү)-ний зарчмуудыг бататгах газар/амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийн ерөнхий үнэлгээг төслийн төлөвлөлтийн явцтай уялдуулан гүйцэтгэснийг баталгаажуулах үүрэг бүхий хүмүүсийг татан оролцуулна.

Нарны цахилгаан станцийн цаашдын хөрөнгө оруулалтанд зориулсан ямарваа боломжит байршлын хувьд үндсэн шаардлагуудад нийцсэн байдлыг нягтална. Албадан газар чөлөөлөлтөөс зайлсхийх боломжгүй тохиолдолд албадан Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд суурилсан Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ) буюу Нүүлгэн шилжүүлэлтийн товч төлөвлөгөө (НШТТ) шаардлагатай болно (Хавсралт В-г үзнэ үү). ТУН нь ББЭХС-тэй хамтран Нүүлгэн шилжүүлэлтийн ямарваа төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

## 6.4 Зөвлөлдөх хэлэлцүүлэг

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
Дэд төслийн багц тус бүрт зориулсан БОСНБЖ-ийг боловсруулах явцад БЗӨБЦТС ба ЭБЦТС-нээс орон нутгийн иргэдэд тохиромжтой хэлбэр (асуулга судалгаа, уулзалт, самбар гэх мэт)-ээр, Дэлхийн Банкны шаардлагуудад нийцүүлэн хамгийн багадаа нэг олон нийтийн зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгуулах ёстой.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Нарны фотовольтийн эрчим хүчний байгууламжид зориулсан БОУТ-г боловсруулах явцад ББЭХС-нээс орон нутгийн иргэдэд тохиромжтой хэлбэр (асуулга судалгаа, уулзалт, самбар гэх мэт)-ээр, Дэлхийн Банкны шаардлагуудад нийцүүлэн хамгийн багадаа нэг олон нийтийн зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгуулах ёстой болно.

Бүрэлдэхүүн хэсэг 1 ба Бүрэлдэхүүн хэсэг 2
Байгаль орчны нөлөөллийн талаарх гол дүгнэлт болон санал болгож буй нөлөөлөл багасгах арга хэмжээний талаарх мэдээллийг өртсөн иргэдийн олонхид ойлгомжтой орон нутгийн хэлээр олон нийтэд танилцуулна. Олон нийтийн хэлэлцүүлгийн тэмдэглэлийг эцсийн БОМТ/БОСНБЖ-ийн багцад дараах мэдээллийг хамгийн багадаа агуулан, хавсаргавал зохино:

- Зөвлөлдөх хэлэлцүүлгийн мэдэгдлийг зарласан хэлбэр: ашигласан хэвлэл мэдээллийн хэрэгсэл(үүд), огноо, зөвлөлдөх арга хэмжээг урьдчилан мэдэгдэхэд хангалттай хугацааг харуулсан зарлалын тайлбар буюу хуулбар, баримт бичгийг олон нийтэд ил тод танилцуулах болон санал хүсэлт ирүүлэх боломж.
- Зөвлөлдөх хэлэлцүүлэг(үүд) зохион байгуулагдсан огноо(нууд)

- Зөвлөлдөх хэлэлцүүлэг(үүд) зохион байгуулагдсан байршил(ууд)
- Уригдсан хүмүүс
  Нэр, байгууллага эсхүл мэргэжил, утас/факс/имейл хаяг /дугаар (гэр ба/буюу ажлын)
- Оролцсон хүмүүс
  Нэр, байгууллага эсхүл мэргэжил, утас/факс/имейл хаяг /дугаар (гэр ба/буюу ажлын)
- Уулзалтын хөтөлбөр буюу хуваарь
- Хэн, юу танилцуулсан
- Уулзалтын товч тэмдэглэл (санал, асуулт болон илтгэл танилцуулагчдын хариултууд)
- Хуваарь, эцсийн хугацаа болон үүрэг хариуцлагын талаарх хүрсэн шийдвэр болон ямарваа арга хэмжээний жагсаалт

Олон нийтийн зөвлөлдөх уулзалтанд тодорхойлсон ямарваа чухал холбогдох асуудлуудыг БОСНБЖ (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу БОУТ (Бүрэлдэхүүн хэсэг 2)-ний төсөлд оруулвал зохино. Олон нийтийн зөвлөлдөх хэлэлцүүлгээс ирүүлсэн ямарваа санал бүхий БОМТ/БОСНБЖ-ын эцсийн хувилбарт тус баримт бичигт олон нийтийн байгаль орчны талаар тавьсан асуудлууд болон байгаль орчныг сайжруулах зөвлөмжүүдийг тусгасан тухай тодорхой мэдэгдлийг оруулах хэрэгтэй. БЗӨБЦТС ба ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) нь дэд төслийн баримт бичигт БОСНБЖ-ын эцсийн төслийг тусгасан байвал зохино.

Дэд төсөлд зориулан бэлтгэсэн ямарваа Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний зөвлөлдөх хэлэлцүүлэгт тавих тусгай шаардлагуудыг Хавсралт В-гийн Хэсэг В10-т үзүүлэв.

## 6.5 Хянах, батлах ба олон нийтэд мэдээлэх

### *Хянах ба батлах*

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
*БЗӨБЦТС ба ЭБЦТС компаниудын эхний хоёр дэд төслийн БОСНБЖ-ын баримт бичиг (нийт дөрөв)*-ийг Дэлхийн Банкны ажлын хэсэг болон Нийгмийн хамгааллын бодлогын мэргэжилтнүүдэд баталгаажилт ба “үл татгалзал” авах зорилгоор хүргүүлэх ёстой.

Төслийн санхүүжүүлэх дэд төслүүд нь харьцангуй бага дэвсгэр нутгийг хамарсан ба олон тохиолдолд өөр байршил олдох боломжтой учир айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхгүй гэж тооцоолж байна. Гэхдээ ямар нэгэн дэд төсөлд дээрх төрлийн нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай болвол Дэлхийн Банкнаас урьдчилан зөвшөөрөл авах ба нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө буюу нүүлгэн шилжүүлэлтийн товч төлөвлөгөөг бэлтгэвэл зохино. Ямарваа нөлөөлөл нь хэмжээ болон хэлбэрээрээ бага байх учир товчилсон НШТ байхаар тооцоолж байна. НШТ боловсруулах тохиолдолд ТУН нь уг НШТ-г Дэлхийн Банкинд хянуулж, батлуулахаар хүргүүлнэ.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
*Эхний дэд төслийн БОУТ*-г Дэлхийн Банкны ажлын хэсэг болон Нийгмийн хамгааллын бодлогын мэргэжилтнүүдэд баталгаажилт ба “үл татгалзал” авах зорилгоор хүргүүлэх ёстой.

Ирээдүйн дэд төслүүдийг төрийн эзэмшлийн газар дээр байрлана гэж тооцоолж буй учир айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхгүй гэж тооцоолж байна. Гэхдээ ямар нэгэн дэд төсөлд дээрх төрлийн нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай болвол Дэлхийн Банкнаас урьдчилан зөвшөөрөл авах ба нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө буюу нүүлгэн шилжүүлэлтийн товч төлөвлөгөөг Хавсралт В-гийн дагуу бэлтгэвэл зохино.

ТУН нь НШТ-г хянуулах ба батлуулахаар Дэлхийн Банкинд хүргүүлнэ. Дэлхийн Банкнаас НШТ-г хянан, зөвшөөрөл олгоно.

### *Олон нийтэд мэдээлэх*

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
Дэд төслийн хэрэгжилтийн өмнө БЗӨБЦТС ба ЭБЦТС нь Дэлхийн Банкны Улаанбаатар хот дахь суурин төлөөлөгчийн газарт эцсийн батлагдсан БОСНБЖ-ын Англи хэл дээрх хувирлбарыг Infoshop-д байрлуулан, олон нийтэд мэдээлэхээр хүргүүлнэ. БЗӨБЦТС ба ЭБЦТС нь мөн төслийн байршлуудын ойролцоох олон нийтийн байршил (жишээ нь засаг захиргааны барилга, сургууль, номын сан гэх мэт)-д ба/буюу өөрсдийн цахим хуудаснаа эцсийн батлагдсан БОСНБЖ-ын Монгол хэл дээрх хувирлбарыг олон нийтэд ил тод мэдээлнэ.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Дэд төслийн хэрэгжилтийн өмнө ТУН нь Дэлхийн Банкны Улаанбаатар хот дахь суурин төлөөлөгчийн газарт эцэслэн батлагдсан БОУТ-ний Англи хэл дээрх хувирлбарыг Infoshop-д байрлуулан, олон нийтэд мэдээлэхээр хүргүүлнэ. ТУН нь ББЭХС-тэй хамт мөн төслийн байршлуудын ойролцоох олон нийтийн байршил (жишээ нь засаг захиргааны барилга, сургууль, номын сан гэх мэт)-д ба/буюу өөрсдийн цахим хуудаснаа эцэслэн батлагдсан БОУТ-ний Монгол хэл дээрх хувирлбарыг олон нийтэд ил тод мэдээлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 1 ба Бүрэлдэхүүн хэсэг 2
Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний хувьд ТУН нь БЗӨБЦТС ба ЭБЦТС эсвэл ББЭХС-тэй хамтран өртсөн иргэд болон төслийн газар нутаг дах нийт ард иргэдэд төсөл болон эцсийн хувилбаруудыг өөрсдийн цахим хуудсаар дамжуулан мөн тэдгээр иргэдийн хандах боломжтой байршилд, ашиглах боломжтой хэлээр хэвлэмэл хувилбараар танилцуулна. Дэлхийн Банктай хамтран гүйцэтгэх энэ болон цаашдын ямарваа төсөлд НШТ-ний төслийг олон нийтэд ил тод мэдэгдэх үл ажиллагааг Дэлхийн Банкны хяналтаас хамгийн багадаа нэг сарын өмнө зохион байгуулна. Эцсийн НШТ-г олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг Дэлхийн Банкнаас хүлээн зөвшөөрсний дараагаар гүйцэтгэнэ. Хавсралт В-гийн Хэсэг В6-гаас дэлгэрэнгүй үзнэ үү.

## 6.6 Хууль тогтоомж/гэрээгээр хүлээх үүргүүд (Нөхцлүүд)

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
БЗӨБЦТС ба ЭБЦТС нь боловсруулсан ямарваа тендерийн баримт бичигт БОСНБЖ-ийг оруулах ба улмаар байгуулсан ямарваа гэрээ (нүүд) нь БОСНБЖ-ны хувийг хавсаргахаас гадна эдгээр заасан БОСНБЖ-д тодорхойлсон шаардлагуудыг Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч дагахыг шаардсан заалтыг тодорхой оруулсан байвал зохино.

БЗӨБЦТС ба ЭБЦТС нь дэд төсөл тус бүрт зориулан бэлтгэсэн ямарваа НШТ-нд заасан гүйцэтгэгчтэй холбоотой арга хэмжээ, шаардлагууд (барилга угсралтын явцад өртсөн иргэдэд[2] үзүүлэх нөлөөлөлд хамаарахын хэрээр)-ыг гүйцэтгэгчээр мөрдүүлэхийг шаардсан заалтуудыг ажлын тендерийн бүх баримт бичиг болон гэрээнд тусгасан байвал зохино.

Уг заалтанд гүйцэтгэгч нь дэд төсөлд зориулан бэлтгэсэн ямар нэгэн НШТ-д тусгагдаагүй, барилга угсралтын ажлын үеэр үүссэн ямарваа урьдчилан тооцоолоогүй нүүлгэн шилжүүлэлтийн эрсдэл буюу нөлөөллийн талаар БЗӨБЦТС ба ЭБЦТС-нд бичгээр мэдэгдэх ба Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажил дуусгавар болоход зам харгүй, бусад орон нутгийн дэд бүтэц болон хөдөө аж ахуйн газрыг наад зах нь төслийн өмнөх нөхцөлд байдал руу нь бүрэн сэргээх ёстой гэж тусгавал зохино.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*

---
[2] Хавсралт В, Хэсэг В.2-оос Өртсөн иргэдийн тодорхойлолтыг үзнэ үү.

ТУН нь боловсруулсан ямарваа тендерийн баримт бичигт БОННҮ-нээс БОУТ-г оруулах ба улмаар байгуулсан ямарваа гэрээ (-нүүд) нь БОУТ-ний хувийг хавсаргахаас гадна эдгээр заасан БОУТ-нд тодорхойлсон шаардлагуудыг Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч дагахыг шаардсан заалтыг тодорхой оруулсан байвал зохино.

ТУН нь дэд төсөл тус бүрт зориулан бэлтгэсэн ямарваа НШТ-нд заасан гүйцэтгэгчтэй холбоотой арга хэмжээ, шаардлагууд (барилга угсралтын явцад өртсөн иргэдэд[3] үзүүлэх нөлөөлөлд хамаарахын хэрээр)-ыг гүйцэтгэгчээр мөрдүүлэхийг шаардсан заалтуудыг ажлын тендерийн бүх баримт бичиг болон гэрээнд тусгасан байвал зохино.

Уг заалтанд гүйцэтгэгч нь дэд төсөлд зориулан бэлтгэсэн ямар нэгэн НШТ-д тусгагдаагүй, барилга угсралтын ажлын үеэр үүссэн ямарваа урьдчилан тооцоолоогүй нүүлгэн шилжүүлэлтийн эрсдэл буюу нөлөөллийн талаар ТУН-д бичгээр мэдэгдэх ба Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажил дуусгавар болоход зам харгуй, бусад орон нутгийн дэд бүтэц болон хөдөө аж ахуйн газрыг наад зах нь төслийн өмнөх нөхцөлд байдал руу нь бүрэн сэргээх ёстой гэж тусгавал зохино.

## 6.7 Хэрэгжүүлэх зохион байгуулалт ба үүрэг хариуцлага

### *Хяналт тавих*

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
БЗӨБЦТС ба ЭБЦТС нь БОСНБЖ-ын байгаль орчны хяналт тавих үйл ажиллагааг хариуцна. Харин Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч нь БОСНБЖ-ын хэрэгжилтийн өдөр тутмын хяналтыг барилга угсралтын явцад хариуцна. ТУН нь (БЗӨБЦТС ба ЭБЦТС-тэй хамтран) нь төслийн хүрээнд бэлтгэсэн аливаа НШТ-ний хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагааг хариуцна. Ямарваа НШТ-ны хяналт тавих шаардлагуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт В-д үзүүлэв.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
ББЭХС нь БОУТ-ний байгаль орчны хяналт тавих үйл ажиллагааг хариуцна. Харин Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч нь БОУТ-ний хэрэгжилтийн өдөр тутмын хяналтыг барилга угсралтын явцад хариуцна. ТУН нь (ББЭХС-тэй хамтран) нь төслийн хүрээнд бэлтгэсэн аливаа НШТ-ний хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагааг хариуцна. Ямарваа НШТ-ний хяналт тавих шаардлагуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт В-д үзүүлэв.

### *Тайлагнах*

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
Барилга угсралтын явцад Гүйцэтгэгч нь заасан хуваарийн дагуу БОСНБЖ-уудыг хэрэгжүүлж байгаа талаарх бичгэн баталгаажилтыг БЗӨБЦТС ба ЭБЦТС-нд ердийн тайлангийн журмын нэг хэсгийн дагуу ирүүлэх ёстой.

БЗӨБЦТС ба ЭБЦТС нь Дэлхийн Банкинд ирүүлэх ердийн тайландаа бүх дэд төслүүдийн БОСНБЖ-ын хэрэгжилтийг хураангуйлан, үүссэн хамгааллын асуудлууд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж байгаа болох шийдвэрлэхийг тайлбарласан “хамгааллын арга хэмжээ” бүлгийг тусгавал зохино.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Барилга угсралтын явцад Гүйцэтгэгч нь заасан хуваарийн дагуу БОУТ-г хэрэгжүүлж байгаа талаарх бичгэн баталгаажилтыг ББЭХС-д ердийн тайлангийн журмын нэг хэсгийн дагуу ирүүлэх ёстой.

ТУН нь Дэлхийн Банкинд ирүүлэх ердийн тайландаа бүх дэд төслүүдийн БОУТ-ний хэрэгжилтийг

[3] Хавсралт В, бүлэг ХВ.1-ээс Өртсөн иргэдийн тодорхойлолтыг үзнэ үү.

хураангуйлан, үүссэн хамгааллын асуудлууд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж байгаа болох шийдвэрлэхийг тайлбарласан "хамгааллын арга хэмжээ" бүлгийг тусгавал зохино.

Бүрэлдэхүүн хэсэг 1 ба Бүрэлдэхүүн хэсэг 2
Цаашдын нарны цахилгаан станцийг оруулан дэд төслүүдэд зориулан ямарваа НШТ боловсруулсан тохиолдолд шаардлагатай НШТ тус бүрт тухайн дэд төсөлд зориулсан хяналт болон явцийн тайлангийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй зохицуулалтыг оруулна (дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт В болон Хавсралт Г-ээс үзнэ үү).

## 7. ЧАДАВХ ХӨГЖҮҮЛЭЛТ

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*
БЗӨБЦТС ба ЭБЦТС компаниуд нь энэхүү БОНУХ-нд заасан үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд бүрэн бэлтгэлтэй байхын тулд Дэлхийн Банкны байгаль орчны хамгааллын сургалтанд зориулан тус бүр нэг мэргэжлийн хүн (мэнд, аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан) мөн нийгмийн хамгааллын сургалтанд өөр нэг хүнийг сонгосон болно. 2016 оны 10 дугаар сар (4-ний өдөр)-д Дэлхийн Банкны хамгааллын мэргэжилтэн анхан шатны хамгааллын талаар товч мэдээлэл тэдгээр мэргэжилтнүүдэд өгсөн болно. Дэлхийн Банкны Бээжин дэх хамгааллын мэргэжилтэн нэмэлт сургалтыг 2017 оны эхний хагаст Улаанбаатар хотноо зохион байгуулна.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
ББЭХС-д хамгааллын хоёр мэргэжилтэн (нэг нь байгаль орчны, нөгөө нь нийгмийн мэргэжилтэн байна) томилно. Эдгээр ажлын байранд нэр дэвшигчдийг эзэмшсэн ур чадвар, сонирхол болон суралцах хүсэл эрмэлзэлд нь тулгуурлан сонгоно. Уг мэргэжилтэнгүүд нь дээр дурсдны дагуу ТУН-ий хамгааллын мэргэжилтний хамт чадавх бэхжүүлэх сургалтанд хамрагдана.

ТУН, Бүрэлдэхүүн хэсэг 1 ба Бүрэлдэхүүн хэсэг 2
Төслийн бэлтгэл явцад ТУН-ийн Төслийн менежерт тайлагнах, байгаль орчин, нийгмийн шаардлагуудын аль алиныг зохицуулалтын чадавх бүхий болон уг асуудлыг хариуцсан Хамгааллын мэргэжилтэн (тухайлбал, байгаль орчин, нийгмийн мэргэжилтэн)-г тус нэгжээс томилно. Тус ажилтан нь БОНУХ болон НШБХ-ний дагуух үүрэг хариуцлагуудыг (дээр дурдсны дагуу) хэрэгжүүлэх боломжтой болохыг тулд Дэлхийн Банкны хамгааллын сургалтанд мөн хамрагдана. Төслийн эхэн үе шатанд дэд төсөл тус бүрт зориулан байгаль орчин, нийгмийн үндсэн шаардлагад нийцсэн байдлын талаарх сургалт (Дэд төслийн үндсэн шаардлагад нийцсэн байдлын талаарх 6.1 хэсгийг үзнэ үү)-нд тусгайлан анхаарах болно.

## 8. ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦОО

БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) нь нь өртөмхий газрууд (эмнэлэг, сургууль, номын сан зэрэг)-ын ойролцоо эсвэл онцгой цаг хугацаа (баяр наадам, амралт, шашны ёслолын өдрүүд гэх мэт)-ны үеэр барилга угсралтын үйл ажиллагааны тогтоосон хуваарийг орон нутгийн эрх бүхий хүмүүс (орон нутгийн доод нэгж, тосгоны удирдлагууд)-тэй харилцан тохиролцоно. БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) нь орон нутгийн иргэдэд барилга угсралт ба ажлын хуваарь, үйлчилгээний тасалдал, замын хөдөлгөөний өөрчилсөн чиглэл, түр хугацааны автобусны чиглэл, тэслэх ба нураах үйл ажиллгааны талаар зохих байдлаар мэдээлнэ.

Аливаа өртсөн иргэдэд санал хүсэлт, гомдлын талаарх дуу хоолойгоо хүргэх боломжоор хангахын тулд барилга угсралтын ажлын бүх талбар дээр төслийн талаарх мэдээллээс гадна талбар хариуцсан менежер, байгаль орчны ажилтан, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаа хариуцсан албан хаагчидтай холбогдох мэдээлэл, утасны дугаар, бусад холбоо барих мэдээллийг агуулсан Мэдээллийн самбарыг байрлуулна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч нь орон нутгийн иргэдийн ойролцоо буюу дунд төвөг чирэгдэл, үймээн самуун үүсгэхгүй байвал зохино.

Эдгээр БОСНБЖ болон байгаль орчны хамгааллын бусад холбогдох баримт бичгүүдийн хуулбарыг тус төслийг эхлүүлэхэд орон нутгийн иргэд болон талбар дээрх ажилчид танилцуулна. БЗӨБЦТС ба ЭБЦТС нь барилга угсралтын талбай дээрх үйл ажиллагаа, төслийн явц болон төслийн хэрэгжилтын үр дүнгийн талаарх мэдээллийг сонирхсон этгээдүүдийг авах боломжоор хангах зорилгоор иргэдтэй харилцах хүнийг томилон ажиллуулна.

Цахилгаан түгээх дэд бүтцийн шинэчлэлтэй холбогдуулан дэд төслүүдийн биет нөлөөллөөс үүдэн гомдол гарч болзошгүй юм. Эдгээр нь байгаль орчинд учруулсан хор хохирол, газар, үл хөдлөх хөрөнгө эсвэл амьжиргааны асуудлууд, барилга угсралтын ажлын нөлөөлөл эсвэл ослоос үүсэх боломжтой юм. Шалтгаанаас үл хамааран, өргөдөл гомдлын тогтолцоо нь өртсөн иргэдийн бүх хэсэг ямар нэгэн зардал, хариу цээрлүүлэлтээс ангид, шуурхай хандах боломжтой, хариуцлагатай бөгөөд соёлын хувьд тохиромжтой ил тод процессийг ашиглан өртсөн иргэдийн гомдол, саналыг шуурхай шийдвэрлэнэ.

Гомдлын шийдвэрлэх процесс нь тухайн гомдлын цар хүрээнд тохируулан арга хэмжээг санал болгоно. Уг процесс нь дараах байдлаар явагдана:

- Хэвийн ажлын үйл ажиллагааны үеэр гүйцэтгэгчид буюу БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) -ний албан хаагчдын шийдвэрлэх боломжтой санал, гомдлыг нэн даруй шийдвэрлэнэ. Тус гомдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (юу, хэзээ, огноо, өдрийн цаг, хүйс, бусад ажиглалтууд), гомдол мэдүүлэгчийн холбоо барих мэдээлэл, арга хэмжээ/хэмжээнүүд болон хаасан огноо зэргийг тэмдэглэнэ. Гомдлыг утсаар, шуудан, цахим шуудангаар БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) рүү эсвэл БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) рүү гомдлыг уламжлах сумын төлөөлөгчид биеэр гаргах боломжтой.
- Нэн даруй буюу гүйцэтгэгч, БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) -ний албан хаагчдын шийдвэрлэх боломжгүй төсөлтэй холбоотой бусад гомдлыг боломжтой бол ажлын арван таван өдөрт багтаан богино хугацаанд зуучлуулахаар ТУН-ийн хамгааллын мэргэжилтэнд эхлээд мэдэгдэнэ. ТУН-ийн хамгааллын мэргэжилтэн нь өртсөн хүн (хүмүүс) буюу өртсөн бүлгийн оршин суугаа газартай ойр газар нээлттэй зөвөлгөөнд гомдолтой холбогдох этгээдүүд болон гомдол мэдүүлэгчийг оролцуулан зуучлах сонсголыг зохион байгуулна. Гомдол мэдүүлэгч нь тус явцад дэмжигчидын хамт оролцохыг дэмжинэ.
- Хэрэв зуучлалын үйл ажиллагаа амжилтгүй болвол эсхүл уг асуудал нь үндэслэлтэй бол өртсөн этгээд нь аль ч хугацаанд Монгол Улсын хууль тогтоомж, журамд нийцүүлэн Монголын шүүх тогтолцоогоор дамжуулан бичгэн буюу аман гомдол гаргаж болно.

Ямар ч үед төслийн гомдол шийдвэрлэх тогтолцоо тухайн санал, гомдлыг шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзвэл Дэлхийн Банкны гомдол шийдвэрлэх үйлчилгээ болон Дэлхийн Банкны Хяналт шалгалтын комисст хандах боломжтой юм. Дэлхийн Банкны Гомдол шийдвэрлэх үйлчилгээ (ГШҮ)-нд гомдол хэрхэн мэдүүлэх тухай мэдээллийг http://www.worldbank.org/GRS хаягаар үзэж болно. Дэлхийн Банкны Хяналт шалтгалтын комисст гомдол хэрхэн мэдүүлэх тухай мэдээллийг www.inspectionpanel.org хаягаар үзэж болно.

Хүлээн авсан бүх гомдлыг ТУН-ийн Хамгааллын мэргэжилтнээр тэмдэглүүлэн, хүргүүлэх ба ТУН дээр гомдол мэдүүлэгчийн талаарх мэдээлэл, огноо, гомдлын шалтгаан, асуудлыг шийдвэрлэхээр авсан алхмууд, үр дүн ба огноо, цаашид авах алхмууд, эцсийн шийдвэрлэх хугацаа болон эцсийн шийдвэрлэх хугацаа хүртэл эхний мэдэгдлээс хойш өнгөрсөн хугацааг тэмдэглэсэн матрикст гомдлуудыг нэгтгэнэ. Уг матриксийг Дэлхийн Банкны ажлын хэсэг тогтмол хянах боломжтой байхаар шинэчлэн, тогтмол тайланд нэг хэсэг болгон оруулна. Гомдлын шалтгаанудын талаарх дүн шинжилгээг цаашдын дэд төслийн төлөвлөлтийг зохих байдлаар сайжруулах үндэслэл болгох зорилгоор гүйцэтгэнэ.

Төслийн талаарх олон нийтийн бүх харилцаа холбоо (мэдээлэх самбар зэрэг) ба зөвлөлдөх хэлэлцүүлэгт гомдол хэрхэн гаргах талаарх мэдээллийг өгнө. Бэлтгэсэн аливаа НШТ нь өртсөн өрхүүд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан гомдол гаргах боломжтой байх болон орон нутгийн түвшинд нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой зохих бололцоог бий болгох нөхцөл байдлаар хангахын тулд дээрх процессийг үргэлжлүүлнэ.

## 9. БОНУХ-НИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*

БЗӨБЦТС/ЭБЦТС нь Бүрэлдэхүүн хэсэг 1-т зориулан боловсруулсан энэхүү БОНУХ-ний баримт бичгийн төслийг хэлэлцэх зорилгоор дараахийг оролцуулсан холбогдох оролцогч талуудтай зөвлөлдсөн болно. Үүнд:

- Энэхүү БОНУХ-ний баримт бичгийн төслийг хэлэлцэх зорилгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар зэрэг төрийн оролцогч байгууллагуудтай хийсэн уулзалтууд.
- Багануур болон Эрдэнэт хотын иргэд, иргэний нийгмийн байгууллага (тухайлбал, эздийн холбоо, бизнес эрхлэгчдийн холбоо), орон нутгийн ТББ-уудыг оролцуулан олон нийтийн хийсэн уулзалтууд.

Олон нийтийн уулзалтууд дээр БОНУХ-ний баримт бичгийн төслийн хуулбаруудыг Монгол хэл дээр үзэж, ашиглах боломжтой байсан болно. Илтгэл танилцуулгуудыг энгийн ойлгомжтой хэллэгээр газрын зураг холбогдох тоног төхөөрөмжийн зургийг үзүүлэн, танилцуулсан. Оролцогчдод төслийн үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчин, тэдгээрийн эрх болон төслийн талаарх саналаа хэрхэн мэдүүлэх буюу гомдол гаргах талаар зөвлөгөө өгсөн болно. Танилцуулга хийгч нь хэлэлцүүлэгт зориулан хангалттай хугацаа гаргасан. Уулзалтын үеэр гарсан санал болон шийдвэрийг Хавсралт Г-1-т үзүүлэв. Эдгээрийг техникийн багийн гишүүдэд санал болгон хүргүүлсэн ба энэхүү БОНУХ-г шинэчлэн боловсруулахад ашигласан болно. БОСНБЖ-д ажлын цагийг тодорхой заах (тухайлбал, өглөөний 7 цагаас оройн 6 цагын хооронд) мөн дахин боловсруулах хаягдлыг ангилах, зайлуулах шаардлагыг гэрээт гүйцэтгэгч нарт тавих зэрэг зүйлсийг оруулсныг тэмдэглэж байна.

Зөвлөлдөх уулзалтын үр дүнд тулгуурлан БЗӨБЦТС/ЭБЦТС компаниуд тус БОНУХ-г эцэслэсэн.

БОНУХ-г зөвлөлдөх хэлэлцүүлгийн оролцогчдын жагсаалт болон уулзалтын тэмдэглэл мөн олон нийтэд ил болгох үйл ажиллагааны хураангуйг Хавсралт Г-1-т үзүүлэв. Тус БОНУХ-ний Багануур хотод зохион байгуулсан зөвлөлдөх хэлэлцүүлэгт 48 хүн, Эрдэнэт хотод зохион байгуулсан зөвлөлдөх хэлэлцүүлэгт 30 хүн тус тус оролцсон болно. Зөвлөлдөх уулзалтын зарыг сонин, зурагт хуудас болон орон нутгийн радиогоор дамжуулан олон нийтэд хүргэсэн болно.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*

ТУН ба ББЭХС нь Бүрэлдэхүүн хэсэг 2-т зориулан боловсруулсан энэхүү БОНУХ-ний баримт бичгийн төслийг дараахийг оролцуулсан холбогдох оролцогч талуудтай зөвлөлдсөн болно. Үүнд:

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар зэрэг төрийн оролцогч байгууллагуудтай хийсэн уулзалтууд.
- Дэлхийн байгаль хамгаалах сан, Монголын зэрлэг амьтан судлах, хамгаалах төв зэрэг холбогдох ТББ-уудтай уулзалтууд.
- Бүлэг 1 дэд төслийн нарны цахилгаан станцийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өртөж болзошгүй иргэд зэрэг Баруун аймгуудын иргэд.

Олон нийтийн уулзалтууд дээр БОНУХ-ний баримт бичгийн төслийн хуулбаруудыг Монгол хэл дээр үзэж, ашиглах боломжтой байсан болно. Илтгэл танилцуулгуудыг энгийн ойлгомжтой хэллэгээр газрын зураг

холбогдох тоног төхөөрөмжийн зургийг үзүүлэн, танилцуулсан. Оролцогчдод төслийн үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчин, тэдгээрийн эрх болон төслийн талаарх саналаа хэрхэн мэдүүлэх буюу гомдол гаргах талаар зөвлөгөө өгсөн болно. 2016 оны 12 сарын 2-ны өдөр зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын оролцогчдын жагсаалт болон уулзалтын тэмдэглэл мөн олон нийтэд ил болгох үйл ажиллагааны хураангуйг Хавсралт Г-2-т үзүүлэв. Олон нийтийн зөвлөлдөх уулзалтанд 60 оролцогч оролцов.

Зөвлөлдөх уулзалтын үр дүнд тулгуурлан ТУН нь тус БОНУХ-г эцэслэсэн.

БХБНБГ-ын зөвлөмжийн дагуу Бүрэлдэхүүн хэсэг 1-т зориулсан БОНУХ-г Бүрэлдэхүүн хэсэг 2-ын БОНУХ-тай нэгтгэн, энэхүү нэгтгэсэн БОНУХ-г боловсруулав. Энэхүү нэгтгэсэн БОНУХ-г төслийн үйл ажиллагааны гар авлагад оруулна. Үнэлгээний өмнө ТУН-ээс тус БОНУХ-г Монгол хэлнээ өөрсдийн цахим хуудсанд байршуулах ба БОНУХ-ний Англи хэл дээрх хувилбарыг Дэлхийн Банкны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар руу олон нийтэд ил болгох зорилгоор хүргүүлнэ.

ХАВСРАЛТ А-1: ХАМГААЛЛЫН ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮСНЭГТ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1

| Асуудал | Батлах хэлбэр (Зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, албан бичиг г.м.) ба батлах эрх бүхий байгууллага | Баталсан огноо | | Хавсаргасан баримт бичиг |
|---|---|---|---|---|
| | | Хүлээн авсан | Хүлээгдэж буй | |
| Байгаль орчны үнэлгээ | БОНХАЖЯ Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар | | | |
| Байгалийн амьдрах орчих[4] | БОНХАЖЯ Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар | | | |
| Ойн аж ахуй[3] | БОНХАЖЯ Ойн бодлого, зохицуулалтын газар | | | |
| Хог хаягдал зайлуулах-Аюултай бус (цаас, баглаа боодол, мод, хуванцар г.м.) | | | | |
| Хог хаягдал зайлуулах - Аюултай (ашигласан уусгагч, тос, цавуу г.м.) | | | | |
| ПБФ-ийн зохицуулалт | | | | |
| Аюултай эд материалын хадгалалт ба ашиглалт (будаг, уусгагч, түлш, бусад шатах материал) | | | | |
| Галын аюулаас сэргийлэх | | | | |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэнд | | | | |
| Соёлын нөөц[3] | Соёлын өвийн зохицуулалтын газар | | | |
| Шинэ барилгад газар ашиглалтын зөвшөөрөл бий эсэх[3] | | | | |
| Газар чөлөөлөлт ба/буюу нүүлгэн шилжүүлэлттэй хамаарах бол | Аймаг/сумын ЗДТГ. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар. | | | |

[4] Шинэ газар ашиглагдах ба/буюу ямарваа малтлага (соёлын нөөц) хийгдэх тохиолдолд л шаардлагатай.

## ХАВСРАЛТ А-2: ХАМГААЛЛЫН ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮСНЭГТ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2

| Асуудал | Батлах хэлбэр (Зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, албан бичиг г.м.) ба батлах эрх бүхий байгууллага | Баталсан огноо | | Хавсаргасан баримт бичиг |
|---|---|---|---|---|
| | | Хүлээн авсан | Хүлээгдэж буй | |
| Төрийн эзэмшлийн газар | ТУН-ээс хүсэлт гаргах албан тоот ба газар шилжүүлэх/түрээслэх тохиролцооны талаарх сумын засаг даргын баримтжуулалт | | | |
| Байгаль орчны үнэлгээ | БОНХАЖЯ Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар | | | |
| Усны хангамж | Санал болгож буй төслийн байршил дах газар доорх усны худгийн гарцны баталгаатай мэдээлэл. Үндсэн шаардлагын үнэлгээний хүрээнд уг мэдээллийг цуглуулах оролдлого амжилтгүй болох тохиолдолд төслийн дизайны нэг хэсэг болгон уг мэдээлэлтэй болох талбарын судалгааг шаардлагатай юм.<br><br>Ус ашиглах зөвшөөрөл | | | |
| Байгалийн амьдрах орчин[3] | БОНХАЖЯ Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар | | | |
| Ойн аж ахуй[3] | БОНХАЖЯ Ойн бодлого, зохицуулалтын газар | | | |
| Хаягдал ус гаргах зөвшөөрөл | | | | |
| Хог хаягдал зайлуулах- Аюултай бус (цаас, баглаа боодол, мод, хуванцар г.м.) | | | | |
| Хог хаягдал зайлуулах - Аюултай (ашигласан уусгагч, тос, цавуу г.м.) | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Аюултай эд материалын хадгалалт ба ашиглалт (будаг, уусгагч, түлш, бусад шатах материал) | | | | |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэнд | | | | |
| Соёлын нөөц | Соёлын өвийн зохицуулалтын газар | | | |
| Газар чөлөөлөлт ба/буюу нүүлгэн шилжүүлэлттэй хамаарах бол | Аймаг/сумын ЗДТГ. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар. | | | |

## ХАВСРАЛТ Б-1: БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЖУРАМ (БОСНБЖ)

Б1-1. 6-10/0.4 кв трансформатор сэргээн засах

| АСУУДАЛ/ЭРСДЭЛ | СӨРӨГ НӨНӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ |
|---|---|
| Тоосжилт үүсэх/ Агаарын бохирдол<br>(Шинэ трансформаторын суурилуулалт) | Гүйцэтгэгч нь тоос дэгдэлтийг хамгийн бага хэмжээнд байлган, орон нутгийн иргэдэд төвөг учруулахгүй байх тоосжилтыг хянах арга хэмжээг аван, дараах байдлаар аюулгүй ажиллах орчинг бий болгоно:<br>* тоостой авто зам болон барилга угсралтын талбайг услах;<br>* салхинд элэгдэхээс хамгаалан ухсан шороо болон эд материалын овоолгыг бүтээнэ. |
| Дуу чимээ ба чичиргээ | Барилга угсралтын бүх тээврийн хэрэгсэл нь хэт дуу чимээ гаргах, ойр хавийн ямарваа мал сүргийг үргээхээс сэргийлэхийн тулд сайн ажиллагаатай дуу намсгагчтай байх ёстой.<br>Үйл ажиллагааг ердийн ажлын цагаар явуулна<br>Барилга угсралтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн цаг хугацаанд буюу өглөөний 7:00 цагаас оройн 6:00 цагийн хооронд хязгаарлан явуулбал зохих ба энэ хоёр хугацааны аль хатууг баримтлан явуулбал зохино. Хэрэв эдгээр цаг хугацааны хязгаарлалтуудаас гадна ямарваа ажил гүйцэтгэх шаардлагатай болвол: (a) зохих эрх бүхий байгууллагаас заавал зөвшөөрөл авсан байх ба (b) орон нутгийн иргэдэд хангалттай хугацааны өмнө урьдчилж мэдэгдсэн байна.<br>Орон нутгийн байгаль орчны эрх бүхий байгууллагаас ямарваа барилга угсралтын тоног төхөөрөмжийг хэтэрхий дуу чимээтэй гэж үзсэн ба/буюу хэрэв орон нутгийн өртсөн иргэдээс гомдол гарвал тухайн тоног төхөөрөмжийг солино. |
| Химийн эсвэл аюултай эд материал ба/буюу хаягдал (ашигласан тослох материал, будаг, цавуулаг бодис, уусгагч бодис) | *Одоо ашиглагдаж буй трансформатор*<br>Трансформаторт байгаа тосонд полихлорт бифенил (ПБФ) агуулагдаж байх нь бий. Уг тосыг Улаанбаатар хот дахь ПБФ шинжилгээний лаборатори руу илгээвэл зохино.<br>Уг тосонд ПБФ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байвал (>50 ppm) тухайн трансформаторыг Улаанбаатар дахь ПБФ боловсруулах төв рүү явуулан, ПБФ-ийг арилгана.<br>Тосонд ПБФ байхгүй бол (<50ppm) тухайн трансформаторыг цахилгаан түгээх сүлжээний өөр хаа нэгтээ ашиглах боломжтой.<br>Хэрэв тухайн трансформатор ПБФ-ээр бохирдсон тостой ба гоожилттой эсвэл гоожиж байгаа баримт байвал уг тосыг шавхан, ПБФ боловсруулах төвд боловсруулах ба эвдрэлтэй транформаторыг засах эсвэл “хатуу хог хаягдал” (дор үзнэ үү) болговол зохино.<br>Хэрэв уг гоожилтоос хөрс бохирдсон талаар нүдэнд харагдах ямарваа шинж тэмдэг байвал тухайн хөрсийг ухан гаргаж, маш өндөр нягтрал бүхий хуванцар саванд хийвэл зохино. БОНХАЖЯ-нд мэдэгдвэл зохих ба тус яамнаас уг хаягдал (ПБФ-ээр бохирдсон болон бохирдоогүй хөрсний аль алины хувьд)-ыг хэрхэх талаар зааварчилгаа өгөх ёстой болно.<br>*Шинэ трансформатор (туслах байгууламжийн барилга угсралт)* |

| | |
|---|---|
| | Ямарваа барилга байгууламжид хар тугалган суурьтай будаг зэрэг хортой материал хэрэглэж үл болно: ган эсвэл бетонон барилга байгууламжийг хучих ямарваа материалыг БОНХАЖЯ-наас зөвшөөрсөн байвал зохино. |
| Ургамлын хучилт ба экологийн нөөц баялагийг сүйтгэх<br>(Шинэ трансформаторын суурилуулалт) | Аливаа цэвэрлэх талбайг аль болох хамгийн бага хэмжээтэй байлгавал зохино.<br>Барилга угсралтын талбай руу хүрэхэд аль болох одоо байгаа авто зам, маршрутыг ашиглавал зохино. Барилга угсралтын талбай руу орох замыг заавал гаргах шаардлагатай болвол орон нутгийн орчин буюу эдийн засгийн үйл ажиллагаа (хөдөө аж ахуй эсвэл мал аж ахуй г.м.)-нд аль болох хамгийн бага хэмжээгээр саад болох байдлаар чиглэл гаргавал зохино. Барилга угсралт/суурилуулалтанд ашигласан замыг засвар үйлчилгээ ашиглалтанд ашиглавал зохино.<br>Байгалийн ургамлыг хуулж авах тохиолдолд Гүйцэтгэгч нь тулгуур/барилга байгууламж гэх мэтийг хадгалах, хураах зэрэг түр зуурын үйл ажиллагааг оролцуулан сэргээн засах үйл ажиллагааны нөлөөнд өнгөн хөрс нь өртөх бүх газрын өнгөн хөрсийг хуулж авна. Аливаа хуулсан хөрсийг БЗӨБЦТС/ ЭБЦТС-тэй тохирсон газарт дараа дахин ургамалжуулахад ашиглах зорилгоор хураах ба бороо, салхи зэргээс улбаалан алга болохоос зохих байдлаар хамгаална.<br>Ургамлыг цэвэрлэх ба/буюу арчлахад пестицид (гербицид) ашиглахыг үл зөвшөөрнө. Газар цэвэрлэх/арчилгаа нь гар ажиллагаатай буюу механик эсвэл аль аль нь байвал зохино. Ургамлын хучилтыг засгийн газрын зөвшөөрөгдсөн газар руу хаявал зохино.<br>Байгалийн ургамлыг хуулж авахад БЗӨБЦТС/ ЭБЦТС нь БОНХАЖЯ буюу орон нутгийн байгаль орчны эрх бүхий байгууллагаас олгох байгаль орчины зөвшөөрөл буюу эрхийг авна.<br>Хэрэгцээтэй тохиолдолд Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь талбар дотор ямарваа ажил эхлүүлэхийн өмнө ямарваа модыг зүй зохистойгоор хамгаалахад зориулан түр зуурын хамгаалалтын хашааг барина.<br>Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь өөрийн ажилтнуудын зүгээс амьтны аймгийг ямар нэгэн байдлаар агнах, занганд оруулах, буудах, хордуулах үйл ажиллагаа хийлгэхгүй байлгана.<br>Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь хаягдал зайлуулах цэг, барилга угсралтын талбарын байгууламж, ажилчдын камп, овоолго, ажлын талбар болон төслийн барилга угсралтын ажлын үеэр түр зуур ашиглагдах ямарваа газар зэрэг цэвэрлэсэн газруудад тохижилт, зохих ус зайлуулалт болон ургамалжуулалтыг хийн, нөхөн сэргээнэ.<br>Химийн эсвэл аюултай бодисоор бохирдсон хөрсийг аюултай хаягдал гэж үзэн, хуулж авах ба тээвэрлэж, цэвэрлэнэ. БОНХАЖЯ-ны баримтжуулсан зааварчилгаанд суурилан хаягдал зайлуулна. |
| Хатуу хог хаягдал | Гүйцэтгэгч нь ажлын бүх газарт хогийн сав, хаягдал хадгалах болон цуглуулах сав, байгууламжийг байрлуулна.<br>БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрсөн зориулалтын газар дээр хатуу хог хаягдлыг түр хадгалж болно. |

| | |
|---|---|
| | Хог хаягдал агуулах сав нь таглаастай, асгадаггүй, агаарын нөлөө болон хаягдал цуглуулагчдаас хамгаалагдсан байна.<br>Хатуу хог хаягдлыг шатааж, талбар дээр булж эсвэл хаяж үл болно. Хэрэв шатаах гэсэн цорын ганц боломжтой байгаа бол орон нутгийн байгаль орчны эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авбал зохино.<br>Гүйцэтгэгч нь ган, хөнгөн цагаан эсвэл зэс хаягдал зэрэг дахин боловсруулах боломжтой хаягдал, барилгын угсралтын эд хэсэг, хавтан, тавцан, баглаа боодлын материал гэх мэт барилгын дахин ашиглах боломжтой материалуудыг дараа дахин ашиглах, чигжээсээр ашиглах эсвэл БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрлөөр дахин боловсруулах/сэргээх үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй компаниудад зарах зориулалтаар талбар дээр (зориулалтын заасан байршилд) бусад хог хаягдлуудыаас салган, цуглуулна.<br>Өөр байдлаар ашиглагдах боломжгүй хаягдал материалыг цахилгаан түгээх шугамын зам дагуух зориулалтын байршилд цуглуулан, түр хадгална.<br>БОНХАЖЯ-ны баримтжуулсан зааварчилгаанд суурилан хаягдал зайлуулна. Хэрэв гоожилттой эсвэл гоожиж байгаа, ПБФ-гүй тостой нь батлагдсан трансформатор байгаа тохиолдолд эвдрэлтэй транформаторыг засах буюу хаягдал материал болгоно.<br>Гүйцэтгэгч нь ямар ч тохиолдолд байгалийн амьдрах орчин буюу усны голдрил гэх мэт байгаль орчны хувьд эмзэг газруудад ямарваа эд материалыг хаяж үл болно.<br>Ажлын талбараас зайлуулсан хатуу хог хаягдал буюу барилгын хаягдлыг зөвхөн орон нутгийн хог хаягдлын удирдлагын эрх бүхий байгууллагын заасан, албан ёсны зориулалтын газарт хаяна.<br>Ашиглалтын хугацаа нь дуусаагүй эд ангийг шаардлагатай бол БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний бусад талбаруудад хадгалах ба/буюу ашиглана. |
| Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал | Өртсөн өрхүүдэд ажлын хуваарь болон цахилгаан тасалдах төлөвлөгөөний талаарх мэдээллийг хамгийн багадаа 2 хоногийн өмнө өгнө.<br>Одоо ашиглагдаж буй кабел, харилцаа холбооны шугам зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээний шугамд гарсан ямар нэгэн гэмтлийг эрх бүхий байгууллагад мэдээлэн, аль болох хурдан засварлана. Гүйцэтгэгч нь холбогдох зардлыг хариуцна. (ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БАРИМТ БИЧИГТ ОРУУЛАХ) |
| Ажилчид болон олон нийтийн аюулгүй байдал | Монгол Улсын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагуудыг мөрдөнө. (Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7-р бүлэг хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, 83-р зүйл хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны нөхцлөөр хангах, 84-р зүйл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, 85-р зүйл үйлдвэрийн осол, хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс үүдэн ажилтнаас үүссэн хохиролд нөхөн олговор олгох тухай хэсгүүдийг үзнэ үү.) Түүнчлэн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний журмын дагуу мөрдөнө. |

| | |
|---|---|
| | Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь зам тээврийн осол болон иргэд, өртөмхий газруудад учруулах бусад эрсдэлээс сэргийлэх зорилгоор хашаа, хаалт, анхааруулах тэмдэг, гэрэлтүүлэг зэрэг аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг авна.<br>Ажлын цагийн үеэр ажилчид согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.<br>Ажилчдаар хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (ХХХ)-ийн ашиглалтыг чанд мөрдүүлнэ. |
| Санамсаргүй олдворын журам | Хэрэв Барилга угсралтын ажил гүйцэтгэгч нь малтлага эсвэл барилга угсралтын ажлын үеэр булш ба/буюу бунхан зэрэг археологийн, түүхийн ач холбогдол бүхий газар/эд өлгийн зүйлс илрүүлбэл:<br>Санамсаргүй олдвор илрүүлсэн газарт барилга угсралтын үйл ажиллагааг нэн даруй зогсооно;<br>БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний албан хүмүүст мэдэгдэх ба тэдгээр нь соёлын өв хөрөнгө хариуцсан эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ;<br>Тухайн газрыг ямар нэгэн байдлаар сүйтгэх эсвэл хөдөлгөх боломжтой эд зүйлсийг алдахаас сэргийлэн хамгаална. Хөдөлгөх боломжтой эрт дээр үеийн эд юмс эвсэл эмзэг дурсгалын зүйлс олдсон тохиолдолд тухайн газарт хариуцсан эрх бүхийн байгууллага хүлээн авах хүртэл байнгын харуул хамгаалалттай байлгах арга хэмжээ авна;<br>Олдвор илрүүлсэн газар буюу бүсийг тойруулан хүрээ татна.<br>Холбогдох эрх бүхий байгууллага нь дараагийн авах арга хэмжээний талаар шийдвэр гаргатал тухайн газрыг хамгаалах, хадгалах үүрэгтэй.<br>Цаашид хэрхэх талаарх шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргана.<br>Хэрэв тухайн соёлын олдвор олдсон газар ба/буюу үлдэгдэл нь өндөр ач холбогдолтой бөгөөд тухайн газрыг хадгалан хамгаалаыг мэргэжлийн хүмүүс зөвлөн, соёлын олдвор хариуцсан эрх бүхий байгууллагаас шаардвал БЗӨБЦТС/ ЭБЦТС нь уг хүсэлтийг хүлээн аван, тухайн газрыг хадгалан хамгаалах зорилгоор төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтийг хийнэ;<br>Холбогдох байгууллагаас олдворын хэрхэх талаарх шийдвэрийг бичгээр мэдэгдэнэ;<br>Соёлын өвийг хамгаалах асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллагаас бичгээр зөвшөөрөл олгосны дараагаар л барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж болно<br>Дээрх эд өлгийн зүйлсийг хувьдаа ашиглах, ашиг хонжоо олох зорилгоор хөдөлгөсөн ямарваа ажилтанг ажлаас чөлөөлөх ба хуулийн хариуцлага хүлээлгэнэ. |

Б1-2: Одоо ашиглагдаж буй дэд станцуудыг шинэ дэд станцуудаар солих

| АСУУДАЛ/ЭРСДЭЛ | СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ |
|---|---|
| Шинэ дэд станцын талбай нь байгалийн чухал амьдрах орчинд өөрчлөлт хийхэд хамаардаг эсвэл байгалийн чухал бус амьдрах орчинд нөлөөлөхөөр байгаа үед [5] | Дэд төсөлд санал болгосон газруудын газрын зургийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ)-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын даргад зөвшөөрөл авахаар хүргүүлэх |
| Шинэ дэд станцын талбай нь ой мод/ойн экосистемийг сүйтгэх эсвэл өөрчлөхөөр байгаа үед[4] | Дэд төсөлд санал болгосон газруудын газрын зургийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ)-ын ойн асуудал хариуцсан газрын даргад зөвшөөрөл авахаар хүргүүлэх |
| Шинэ дэд станцын талбай нь Монгол Улсын соёлын нөөцөд сөргөөр нөлөөлөхөөр байгаа үед[4] | Дэд төсөлд санал болгосон газруудын газрын зургийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ)-ны соёлын өв зохицуулалт хариуцсан газрын даргад зөвшөөрөл авахаар хүргүүлэх |
| Тоосжилт үүсэх/ Агаарын бохирдол | Гүйцэтгэгч нь тоос дэгдэлтийг хамгийн бага хэмжээнд байлган, орон нутгийн иргэдэд төвөг учруулахгүй байх тоосжилтыг хянах арга хэмжээг аван, дараах байдлаар аюулгүй ажиллах орчинг бий болгоно:<br>- тоостой авто зам болон барилга угсралтын талбайг услах;<br>- эд материалын овоолгыг бүтээнэ;<br>- салхинд элэгдэхээс хамгаалан ухсан шороо болон эд материалын овоолгыг бүтээнэ. |
| Дуу чимээ ба чичиргээ | • Барилга угсралтын бүх тээврийн хэрэгсэл нь хэт дуу чимээ гаргахаас сэргийлэхийн тулд сайн ажиллагаатай дуу намсгагчтай байх ёстой.<br>• Барилга угсралтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн цаг хугацаанд буюу өглөөний 7:00 цагаас оройн 6:00 цагийн хооронд хязгаарлан явуулбал зохих ба энэ хоёр хугацааны аль хатууг баримтлан явуулбал зохино. Хэрэв эдгээр цаг хугацааны хязгаарлалтуудаас гадна ямарваа ажил гүйцэтгэх шаардлагатай болвол: (a) зохих эрх бүхий байгууллагаас заавал зөвшөөрөл авсан байх ба (b) орон нутгийн иргэдэд хангалттай хугацааны өмнө урьдчилж мэдэгдсэн байна.<br>• Орон нутгийн байгаль орчны эрх бүхийн байгууллагаас ямарваа барилга угсралтын тоног төхөөрөмжийг хэтэрхий дуу чимээтэй гэж үзсэн ба/буюу хэрэв орон нутгийн өртсөн иргэдээс гомдол гарвал тухайн тоног төхөөрөмжийг солино. |
| Усны бохирдол | • Дэд төслийн байршил дээр ариун цэврийн байгууламж байхгүй бол ажлын талбар дээр болон/эсвэл ажлын кампд (хэрвээ ийм камп байгуулвал) барилгын ажилчдад зориулан зөөврийн бие засах газраар хангах буюу бие засах газар барьсан байх ёстой. Ямарваа усны эх үүсвэр рүү хүний бохирыг шууд хаяхгүй буюу асгахгүй байвал зохино. |

[5] Энэ нь маш бага магадлалтай хэдий ч урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон зөвлөв

| | |
|---|---|
| | • Байгалийн усны эх үүсвэрт болон ойролцоо газар авто машин, ачааны машин, тоног төхөөрөмжийг угааж үл болно. |
| Ус зайлуулах систем ба тунадасжилт | • Гүйцэтгэгч нь ус зайлуулах системийг шавар болон бусад саад болох зүйлсээс ямагт ангид байхыг хариуцна. |
| Хатуу хог хаягдал (аюултай бус) | • Гүйцэтгэгч нь ажлын бүх газарт хогийн сав, хаягдал хадгалах болон цуглуулах сав, байгууламжийг байрлуулна.<br>• БЗӨБЦТС/ЭБЦТС-ний зөвшөөрсөн зориулалтын газар дээр хатуу хог хаягдлыг түр хадгалж болно.<br>• Хог хаягдал агуулах сав нь таглаастай, асгадаггүй, агаарын нөлөө болон хаягдал цуглуулагчдаас хамгаалагдсан байна.<br>• Хатуу хог хаягдлыг шатааж, талбар дээр булж эсвэл хаяж үл болно. Хэрэв шатаах гэсэн цорын ганц боломжтой байгаа бол БОНХАЖЯ юмуу орон нутгийн байгаль орчны эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авбал зохино.<br>• Гүйцэтгэгч нь ган, хөнгөн цагаан эсвэл зэс хаягдал зэрэг дахин боловсруулах боломжтой хаягдал, барилгын угсралтын эд хэсэг, хавтан, тавцан, баглаа боодлын материал гэх мэт барилгын дахин ашиглах боломжтой материалуудыг дараа дахин ашиглах, чигжээсээр ашиглах эсвэл БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрлөөр дахин боловсруулах/сэргээх үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй компаниудад зарах зориулалтаар талбар дээр (зориулалтын заасан байршилд) бусад хог хаягдлуудыаас салган, цуглуулна.<br>• Гүйцэтгэгч нь ямар ч тохиолдолд байгалийн амьдрах орчин буюу усны голдрил гэх мэт байгаль орчны хувьд эмзэг газруудад ямарваа эд материалыг хаяж үл болно.<br>• Ажлын талбараас зайлуулсан хатуу хог хаягдал буюу барилгын хаягдлыг зөвхөн орон нутгийн хог хаягдлын удирдлагын эрх бүхий байгууллага юмуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам (БОНХАЖЯ)-ны заасан, албан ёсны зориулалтын газарт хаяна. |
| Химийн эсвэл аюултай эд материал ба/буюу хаягдал (ашигласан тослох материал, будаг, цавуулаг бодис, уусгагч бодис, ПБФ агуулсан тоног төхөөрөмжийн шингэн г.м.) | Ашигласан тос, тослох материалыг ажлын талбар дээр үлдээж болохгүй бөгөөд зохих ёсны тусгай зөвшөөрөл бүхий дахин боловсруулах компанид зарна.<br>Ямар ч тээврийн хэрэгсэл ба тоног төхөөрөмжийг арчлахад ашиглагдсан тос, тосолгооны материалыг битүүмжилсэн хайрцагт эсвэл хадгалах саванд цуглуулан, тухайн газраас зөөн зөвшөөрөлтэй тос дахин боловсруулах компанид зарах эсвэл засгийн газрын зөвшөөрсөн газар тушаана.<br>Ямарваа барилга байгууламжид хар тугалган суурьтай будаг зэрэг хортой материал хэрэглэж үл болно: ган эсвэл бетонон барилга байгууламжийг хучих ямарваа материалыг БОНХАЖЯ-наас зөвшөөрсөн байвал зохино.<br>Асбест материалыг ямар ч барилга байгууламжийн барилга угсралт (дээвэр, дотор ба гадна хана г.м) болон тусгаарлагч материал (яндан, сувгийн ажил г.м)-аар ашиглаж болохгүй. |

| | |
|---|---|
| | Хэрэв одоогийн ямар нэг барилга нь асбест материал агуулсан байвал Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь БОНХАЖЯ-ны удирдамжийн дагуу эдгээр материалыг зайлуулах үүрэгтэй.<br><br>*<u>Хуучин трансформатор, тосон хэлхээ салгуур, конденсатор ба бусад цахилгаан тоног төхөөрөмж гэх мэт ПБФ агуулж байж болзошгүй эд ангиудын хувьд</u>*<br>БЗӨБЦТС/ЭБЦТС-ээс тосыг нь Улаанбаатар хот дахь ПБФ шинжилгээний лабораторит илгээх ажлыг зохион байгуулна.<br><br>Эдгээр эд ангиуд нь ямар нэгэн гоожилтгүй бол:<br>Тосонд нь ПБФ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байвал (>50 ppm) БЗӨБЦТС/ЭБЦТС-ээс тосыг Улаанбаатар дахь ПБФ боловсруулах төв рүү явуулан, ПБФ-ийг арилгах ажлыг зохион байгуулна. Тухайн тоног төхөөрөмжийн хувьд ПБФ-гүй тосоор цэнэглэн цахилгаан түгээх сүлжээний өөр хаа нэгтээ ашиглах боломжтой.<br><br>Тосонд ПБФ байхгүй бол (<50ppm) тухайн тоног төхөөрөмжийг цахилгаан түгээх сүлжээний өөр хаа нэгтээ ашиглах боломжтой.<br><br>Эдгээр эд ангиуд нь гоожилттой эсвэл гоожиж байсан нь нүдэнд харагдах баримт байвал:<br>Тосонд нь ПБФ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байвал (>50 ppm) БЗӨБЦТС/ЭБЦТС-ээс тосыг Улаанбаатар дахь ПБФ боловсруулах төв рүү явуулан, ПБФ-ийг арилгах ажлыг зохион байгуулна. Тухайн тоног төхөөрөмжийг засварлан, ПБФ-гүй тосоор цэнэглээд цахилгаан түгээх сүлжээний өөр хаа нэгтээ ашиглах юмуу зохих ёсны тусгай зөвшөөрөлтэй дахин боловсруулах/засварлах компанид хаягдал болгон зарна<br><br>Тосонд ПБФ байхгүй бол (<50ppm) тухайн тоног төхөөрөмжийг засварлан, цахилгаан түгээх сүлжээний өөр хаа нэгтээ ашиглах юмуу зохих ёсны тусгай зөвшөөрөлтэй дахин боловсруулах/засварлах компанид хаягдал болгон зарна<br><br>Хэрэв хөрс болон гадаргын материал гоожилтоос бохирдсон талаар нүдэнд харагдах ямарваа шинж тэмдэг байвал тухайн хөрсийг харагдах бохирдлоос хамгийн багадаа 6 инчийн гадуур ухан гаргаж, маш өндөр нягтрал бүхий хуванцар саванд хийвэл зохино. БОНХАЖЯ-нд мэдэгдвэл зохих ба тус яамнаас уг хаягдал (ПБФ-ээр бохирдсон болон бохирдоогүй хөрсний аль алины хувьд)-ыг хэрхэх талаар зааварчилгаа өгөх ёстой болно. |

| | |
|---|---|
| | *Бүх шинэ цахилгааны тоног төхөөрөмж нь ПБФ-гүй байх ёстой бөгөөд уг шаардлагыг тендерийн бүх баримт бичигт заасан байх ёстой.* |
| Ургамлын хучилт ба экологийн нөөц баялагийг сүйтгэх | • Цэвэрлэх талбайг аль болох хамгийн бага хэмжээтэй байлгавал зохино.<br>• Барилга угсралтын талбай руу хүрэхэд аль болох одоо байгаа авто замыг ашиглавал зохино. Барилга угсралтын талбай руу орох замыг заавал гаргах шаардлагатай болвол орон нутгийн орчинд аль болох хамгийн бага хэмжээгээр саад болох байдлаар чиглэл гаргавал зохино. Барилга угсралт/суурилуулалтанд ашигласан замыг засвар үйлчилгээ ашиглалтанд ашиглавал зохино.<br>• Гүйцэтгэгч нь хадгалах, хураах зэрэг түр зуурын үйл ажиллагааг оролцуулан сэргээн засах үйл ажиллагааны нөлөөнд өнгөн хөрс нь өртөх бүх газрын өнгөн хөрсийг хуулж авна. Аливаа хуулсан хөрсийг БЗӨБЦТС/ ЭБЦТС-тэй тохирсон газарт дараа дахин ургамалжуулахад ашиглах зорилгоор хураах ба бороо, салхи зэргээс улбаалан алга болохоос зохих байдлаар хамгаална.<br>• Ургамлыг цэвэрлэх ба/буюу арчлахад пестицид (гербицид) ашиглахыг үл зөвшөөрнө. Газар цэвэрлэх/арчилгаа нь гар ажиллагаатай буюу механик эсвэл аль аль нь байвал зохино.<br>• Байгалийн ургамлыг хуулж авахад БЗӨБЦТС/ ЭБЦТС нь БОНХАЖЯ буюу орон нутгийн байгаль орчны эрх бүхий байгууллагаас олгох байгаль орчины зөвшөөрөл буюу эрхийг авна.<br>• Хэрэгцээтэй тохиолдолд Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь талбар дотор ямарваа ажил эхлүүлэхийн өмнө ямарваа модыг зүй зохистойгоор хамгаалахад зориулан түр зуурын хамгаалалтын хашааг барина.<br>• Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь хаягдал зайлуулах цэг, барилга угсралтын талбарын байгууламж, ажилчдын камп, овоолго, ажлын талбар болон төслийн барилга угсралтын ажлын үеэр түр зуур ашиглагдах ямарваа газар зэрэг цэвэрлэсэн газруудад тохижилт, зохих ус зайлуулалт болон ургамалжуулалтыг хийн, нөхөн сэргээнэ.<br>• Химийн эсвэл аюултай бодисоор бохирдсон хөрсийг аюултай хаягдал гэж үзэн, хуулж авах ба тээвэрлэж, цэвэрлэнэ. БОНХАЖЯ-ны баримтжуулсан зааварчилгаанд суурилан хаягдал зайлуулна. |
| Замын хөдөлгөөний зохицуулалт | Төслийн барилга угсралтын үе шатанд замын хөдөлгөөний удирдлагын арга хэмжээ авах болвол БЗӨБЦТС/ ЭБЦТС, Барилга угсралтын ажил гүйцэтгэгч нь дараах тохиолдлуудад Монгол Улсын замын хөдөлгөөний эрх бүхий байгууллагаас зааварчилгаа авна. Үүнд:<br>a) тээврийн хэрэгсэл явах тоо тодорхой хэмжээгээр ихэсвэл<br>b) сургууль, эмнэлэг зэрэг өртөмхий газруудыг тооцон замын хөдөлгөөнийг өөрчлөх хэрэгтэй үед.<br>c) замын хөдөлгөөний эргэлтэнд зориулан шөнө гэрэлтүүлэг суурилуулах хэрэгтэй үед. |

| | |
|---|---|
| | Барилга угсралтын ажил үйцэтгэгч нь барилгын ажил хийгдэж байгаа газар ажлын янз бүрийн хэсэг рүү явах замын хөдөлгөөнийг зохицуулах чиглэл заасан тэмдэг тавих ба аюулгүй байдлын зөвлөгөө, анхааруулга байрлуулна.<br>Хэрэв эд материалыг ачаалал ихтэй цагаар тээврийн хэрэгслээр зөөх бол Гүйцэтгэгч орон нутгийн замын хөдөлгөөний газар мэдэгдэн, шаардлагатай тохиолдолд тэднээс тусламж хүснэ.<br>Нураах/барих ажлыг эхлүүлэхээс өмнө БЗӨБЦТС/ ЭБЦТС нь орон нутгийн захиргаа, иргэд, замын хөдөлгөөний газартай зөвлөлдөнө. |
| Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал | • Өртсөн өрхүүдэд ажлын хуваарь болон цахилгаан тасалдах төлөвлөгөөний талаарх мэдээллийг хамгийн багадаа 2 хоногийн өмнө өгнө.<br>• Одоо ашиглагдаж буй кабел, харилцаа холбооны шугам зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээний шугамд гарсан ямар нэгэн гэмтлийг эрх бүхий байгууллагад мэдээлэн, аль болох хурдан засварлана. Гүйцэтгэгч нь холбогдох зардлыг хариуцна. (ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БАРИМТ БИЧИГТ ОРУУЛАХ) |
| Өртсөн бүс нутгийн сэргээн босголт | • Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь хаягдал зайлуулах цэг, барилга угсралтын талбарын байгууламж, ажилчдын камп, овоолго, ажлын талбар болон төслийн барилга угсралтын ажлын үеэр түр зуур ашиглагдах ямарваа газар зэрэг цэвэрлэсэн газруудад тохижилт, зохих ус зайлуулалт болон ургамалжуулалтыг хийн, нөхөн сэргээнэ.<br>• Химийн эсвэл аюултай бодисоор бохирдсон хөрсийг аюултай хаягдал гэж үзэн, хуулж авах ба тээвэрлэж,цэвэрлэнэ.БОНХАЖЯ-ны баримтжуулсан зааварчилгаанд суурилан хаягдал зайлуулна. |
| Ажилчид болон олон нийтийн аюулгүй байдал | Монгол Улсын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагуудыг мөрдөнө. (Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7-р бүлэг хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, 83-р зүйл хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны нөхцлөөр хангах, 84-р зүйл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, 85-р зүйл үйлдвэрийн осол, хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс үүдэн ажилтнаас үүссэн хохиролд нөхөн олговор олгох тухай хэсгүүдийг үзнэ үү.)<br>Түүнчлэн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний журмын дагуу мөрдөнө.<br>Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь зам тээврийн осол болон иргэд, өртөмхий газруудад учруулах бусад эрсдэлээс сэргийлэх зорилгоор хашаа, хаалт, анхааруулах тэмдэг, гэрэлтүүлэг зэрэг аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг авна.<br>Ажлын цагийн үеэр ажилчид согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.<br>Ажилчдаар хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (ХХХ)-ийн ашиглалтыг чанд хэрэгжүүлнэ. |
| Тохиолдлын олдворын журам | Хэрэв Барилга угсралтын ажил гүйцэтгэгч нь малтлага эсвэл барилга угсралтын ажлын үеэр булш ба/буюу бунхан зэрэг археологийн, түүхийн ач холбогдол бүхий газар/эд өлгийн зүйлс илрүүлбэл: |

| | |
|---|---|
| | Санамсаргүй олдвор илрүүлсэн газарт барилга угсралтын үйл ажиллагааг нэн даруй зогсооно;<br>БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний албан хүмүүст мэдэгдэх ба тэдгээр нь соёлын өв хөрөнгө хариуцсан эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ;<br>Тухайн газрыг ямар нэгэн байдлаар сүйтгэх эсвэл хөдөлгөх боломжтой эд зүйлсийг алдахаас сэргийлэн хамгаална. Хөдөлгөх боломжтой эрт дээр үеийн эд юмс эвсэл эмзэг дурсгалын зүйлс олдсон тохиолдолд тухайн газарт хариуцсан эрх бүхийн байгууллага хүлээн авах хүртэл байнгын харуул хамгаалалттай байлгах арга хэмжээ авна;<br>Олдвор илрүүлсэн газар буюу бүсийг тойруулан хүрээ татна.<br>Холбогдох эрх бүхий байгууллага нь дараагийн авах арга хэмжээний талаар шийдвэр гаргатал тухайн газрыг хамгаалах, хадгалах үүрэгтэй.<br>Цаашид хэрхэх талаарх шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргана.<br>Хэрэв тухайн соёлын олдвор олдсон газар ба/буюу үлдэгдэл нь өндөр ач холбогдолтой бөгөөд тухайн газрыг хадгалан хамгаалаыг мэргэжлийн хүмүүс зөвлөн, соёлын олдвор хариуцсан эрх бүхий байгууллагаас шаардвал БЗӨБЦТС/ ЭБЦТС нь уг хүсэлтийг хүлээн аван, тухайн газрыг хадгалан хамгаалах зорилгоор төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтийг хийнэ;<br>Холбогдох байгууллагаас олдворын хэрхэх талаарх шийдвэрийг бичгээр мэдэгдэнэ;<br>Соёлын өвийг хамгаалах асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллагаас бичгээр зөвшөөрөл олгосны дараагаар л барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж болно<br>Дээрх эд өлгийн зүйлсийг хувьдаа ашиглах, ашиг хонжоо олох зорилгоор хөдөлгөсөн ямарваа ажилтанг ажлаас чөлөөлөх ба хуулийн хариуцлага хүлээлгэнэ. |

Б1-3: Тосон хэлхээ салгуурыг солих

| АСУУДАЛ/ЭРСДЭЛ | СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ |
|---|---|
| Дуу чимээ ба чичиргээ | Барилга угсралтын бүх тээврийн хэрэгсэл нь хэт дуу чимээ гаргах, ойр хавийн ямарваа мал сүргийг үргээхээс сэргийлэхийн тулд сайн ажиллагаатай дуу намсгагчтай байх ёстой.<br>Барилга угсралтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн цаг хугацаанд буюу өглөөний 7:00 цагаас оройн 6:00 цагийн хооронд хязгаарлан явуулбал зохих ба энэ хоёр хугацааны аль хатууг баримтлан явуулбал зохино. Хэрэв эдгээр цаг хугацааны хязгаарлалтуудаас гадна ямарваа ажил гүйцэтгэх шаардлагатай болвол: (a) зохих эрх бүхий байгууллагаас заавал зөвшөөрөл авсан байх ба (b) орон нутгийн иргэдэд хангалттай хугацааны өмнө урьдчилж мэдэгдсэн байна.<br>Орон нутгийн байгаль орчны эрх бүхийн байгууллагаас ямарваа барилга угсралтын тоног төхөөрөмжийг хэтэрхий дуу чимээтэй гэж үзсэн ба/буюу хэрэв орон нутгийн өртсөн иргэдээс гомдол гарвал тухайн тоног төхөөрөмжийг солино. |
| Аюултай эд материал | Хуучин тосон хэлхээ салгуурт байгаа тосонд полихлорт бифенил (ПБФ) агуулагдаж байх нь бий. Уг тосыг Улаанбаатар хот дахь ПБФ шинжилгээний лаборатори руу илгээвэл зохино.<br>Уг тосонд ПБФ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байвал (>50 ppm) тухайн тосон хэлхээ салгуурыг Улаанбаатар дахь ПБФ боловсруулах төв рүү явуулан, ПБФ-ийг арилгана.<br><br>Тосонд ПБФ байхгүй бол (<50ppm) тухайн тосон хэлхээ салгуурыг цахилгаан түгээх сүлжээний өөр хаа нэгтээ ашиглах боломжтой.<br><br>Хэрэв тухайн тосон хэлхээ салгуур гоожилттой ба ПБФ-ээр бохирдсон тостой бол уг тосыг шавхан, ПБФ боловсруулах төвд боловсруулах ба эвдрэлтэй тосон хэлхээ салгуурыг засах эсвэл “хатуу хог хаягдал” (дор үзнэ үү) болговол зохино.<br><br>Хэрэв тухайн тосон хэлхээ салгуур гоожилттой ба тос нь ПБФ-ээр бохирдоогүй бол эвдрэлтэй тосон хэлхээ салгуурыг засах эсвэл “хатуу хог хаягдал” (дор үзнэ үү) болговол зохино |
| Хатуу хог хаягдал | Гүйцэтгэгч нь ажлын бүх газарт хогийн сав, хаягдал хадгалах болон цуглуулах сав, байгууламжийг байрлуулна.<br>БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрсөн зориулалтын газар дээрх талбарт хатуу хог хаягдлыг түр хадгалж болно.<br>Хог хаягдал агуулах сав нь тагаастай, асгадаггүй, агаарын нөлөө болон хаягдал цуглуулагчдаас хамгаалагдсан байна.<br>Хатуу хог хаягдлыг шатааж, талбар дээр булж эсвэл хаяж үл болно. Хэрэв шатаах гэсэн цорын ганц боломжтой байгаа бол орон нутгийн байгаль орчны эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авбал зохино.<br>Гүйцэтгэгч нь ган, хөнгөн цагаан эсвэл зэс хаягдал зэрэг дахин боловсруулах боломжтой хаягдал, барилгын угсралтын эд хэсэг, хавтан, тавцан, баглаа боодлын материал гэх мэт барилгын дахин |

| | |
|---|---|
| | ашиглах боломжтой материалуудыг дараа дахин ашиглах, чигжээсээр ашиглах эсвэл БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрлөөр дахин боловсруулах/сэргээх үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй компаниудад зарах зориулалтаар талбар дээр (зориулалтын заасан байршилд) бусад хог хаягдлуудыаас салган, цуглуулна.<br>Өөр байдлаар ашиглагдах боломжгүй хаягдал материал (кабелийн бүрээс г.м) -ыг цахилгаан түгээх шугамын зам дагуух зориулалтын байршилд цуглуулан, түр хадгална.<br>Гүйцэтгэгч нь ямар ч тохиолдолд байгалийн амьдрах орчин буюу усны голдрил гэх мэт байгаль орчны хувьд эмзэг газруудад ямарваа эд материалыг хаяж үл болно.<br>Ажлын талбараас зайлуулсан хатуу хог хаягдал буюу барилгын хаягдлыг зөвхөн орон нутгийн хог хаягдлын удирдлагын эрх бүхий байгууллагын заасан, албан ёсны зориулалтын газарт хаяна.<br>Ашиглалтын хугацаа нь дуусаагүй эд ангийг шаардлагатай бол БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний бусад талбаруудад хадгалах ба/буюу ашиглана. |
| Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал | Өртсөн өрхүүдэд ажлын хуваарь болон цахилгаан тасалдах төлөвлөгөөний талаарх мэдээллийг хамгийн багадаа 2 хоногийн өмнө өгнө.<br>Одоо ашиглагдаж буй кабел, харилцаа холбооны шугам зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээний шугамд гарсан ямар нэгэн гэмтлийг эрх бүхий байгууллагад мэдээлэн, аль болох хурдан засварлана. Гүйцэтгэгч нь холбогдох зардлыг хариуцна. (ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БАРИМТ БИЧИГТ ОРУУЛАХ) |
| Ажилчид болон олон нийтийн аюулгүй байдал | Монгол Улсын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагуудыг мөрдөнө. (Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7-р бүлэг хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, 83-р зүйл хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны нөхцлөөр хангах, 84-р зүйл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, 85-р зүйл үйлдвэрийн осол, хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс үүдэн ажилтнаас үүссэн хохиролд нөхөн олговор олгох тухай хэсгүүдийг үзнэ үү.)<br>Түүнчлэн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний журмын дагуу мөрдөнө.<br>Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь зам тээврийн осол болон иргэд, өртөмхий газруудад учруулах бусад эрсдэлээс сэргийлэх зорилгоор хашаа, хаалт, анхааруулах тэмдэг, гэрэлтүүлэг зэрэг аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг авна.<br>Ажлын цагийн үеэр ажилчид согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.<br>Ажилчдаар хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (ХХХ)-ийн ашиглалтыг чанд мөрдүүлнэ. |

Б1-4: Вакуум хэлхээ салгуурыг суурилуулах

| АСУУДАЛ/ЭРСДЭЛ | СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ |
|---|---|
| Дуу чимээ ба чичиргээ | Барилга угсралтын бүх тээврийн хэрэгсэл нь хэт дуу чимээ гаргах, ойр хавийн ямарваа мал сүргийг үргээхээс сэргийлэхийн тулд сайн ажиллагаатай дуу намсгагчтай байх ёстой.<br>Барилга угсралтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн цаг хугацаанд буюу өглөөний 7:00 цагаас оройн 6:00 цагийн хооронд хязгаарлан явуулбал зохих ба энэ хоёр хугацааны аль хатууг баримтлан явуулбал зохино. Хэрэв эдгээр цаг хугацааны хязгаарлалтуудаас гадна ямарваа ажил гүйцэтгэх шаардлагатай болвол: (a) зохих эрх бүхий байгууллагаас заавал зөвшөөрөл авсан байх ба (b) орон нутгийн иргэдэд хангалттай хугацааны өмнө урьдчилж мэдэгдсэн байна.<br>Орон нутгийн байгаль орчны эрх бүхийн байгууллагаас ямарваа барилга угсралтын тоног төхөөрөмжийг хэтэрхий дуу чимээтэй гэж үзсэн ба/буюу хэрэв орон нутгийн өртсөн иргэдээс гомдол гарвал тухайн тоног төхөөрөмжийг солино. |
| Хатуу хог хаягдал | Гүйцэтгэгч нь ажлын бүх газарт хогийн сав, хаягдал хадгалах болон цуглуулах сав, байгууламжийг байрлуулна.<br>БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрсөн зориулалтын газар дээрх талбарт хатуу хог хаягдлыг түр хадгалж болно.<br>Хог хаягдал агуулах сав нь тагаастай, асгадаггүй, агаарын нөлөө болон хаягдал цуглуулагчдаас хамгаалагдсан байна.<br>Хатуу хог хаягдлыг шатааж, талбар дээр булж эсвэл хаяж үл болно. Хэрэв шатаах гэсэн цорын ганц боломжтой байгаа бол орон нутгийн байгаль орчны эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авбал зохино.<br>Гүйцэтгэгч нь ган, хөнгөн цагаан эсвэл зэс хаягдал зэрэг дахин боловсруулах боломжтой хаягдал, барилгын угсралтын эд хэсэг, хавтан, тавцан, баглаа боодлын материал гэх мэт барилгын дахин ашиглах боломжтой материалуудыг дараа дахин ашиглах, чигжээсээр ашиглах эсвэл БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрлөөр дахин боловсруулах/сэргээх үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй компаниудад зарах зориулалтаар талбар дээр (зориулалтын заасан байршилд) бусад хог хаягдлуудыаас салган, цуглуулна.<br>Өөр байдлаар ашиглагдах боломжгүй хаягдал материалыг цахилгаан түгээх шугамын зам дагуух зориулалтын байршилд цуглуулан, түр хадгална.<br>Гүйцэтгэгч нь ямар ч тохиолдолд байгалийн амьдрах орчин буюу усны голдрил гэх мэт байгаль орчны хувьд эмзэг газруудад ямарваа эд материалыг хаяж үл болно.<br>Ажлын талбараас зайлуулсан хатуу хог хаягдал буюу барилгын хаягдлыг зөвхөн орон нутгийн хог хаягдлын удирдлагын эрх бүхий байгууллагын заасан, албан ёсны зориулалтын газарт хаяна.<br>Ашиглалтын хугацаа нь дуусаагүй эд ангийг шаардлагатай бол БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний бусад талбаруудад хадгалах ба/буюу ашиглана. |

| | |
|---|---|
| Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал | Өртсөн өрхүүдэд ажлын хуваарь болон цахилгаан тасалдах төлөвлөгөөний талаарх мэдээллийг хамгийн багадаа 2 хоногийн өмнө өгнө.<br>Одоо ашиглагдаж буй кабел, харилцаа холбооны шугам зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээний шугамд гарсан ямар нэгэн гэмтлийг эрх бүхий байгууллагад мэдээлэн, аль болох хурдан засварлана. Гүйцэтгэгч нь холбогдох зардлыг хариуцна. (ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БАРИМТ БИЧИГТ ОРУУЛАХ) |
| Ажилчид болон олон нийтийн аюулгүй байдал | Монгол Улсын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагуудыг мөрдөнө. (Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7-р бүлэг хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, 83-р зүйл хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны нөхцлөөр хангах, 84-р зүйл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, 85-р зүйл үйлдвэрийн осол, хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс үүдэн ажилтнаас үүссэн хохиролд нөхөн олговор олгох тухай хэсгүүдийг үзнэ үү.)<br>Түүнчлэн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний журмын дагуу мөрдөнө.<br>Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь зам тээврийн осол болон иргэд, өртөмхий газруудад учруулах бусад эрсдэлээс сэргийлэх зорилгоор хашаа, хаалт, анхааруулах тэмдэг, гэрэлтүүлэг зэрэг аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг авна.<br>Ажлын цагийн үеэр ажилчид согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.<br>Ажилчдаар хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (ХХХ)-ийн ашиглалтыг чанд мөрдүүлнэ. |

Б1-5: Хуучин тоолуурыг ухаалаг тоолуураар солих ба ухаалаг тоолуурыг шинэ хэрэглэгчдэд зориулан суурилуулах

| АСУУДАЛ/ЭРСДЭЛ | СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ |
|---|---|
| Дуу чимээ ба чичиргээ | Барилга угсралтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн цаг хугацаанд буюу өглөөний 7:00 цагаас оройн 6:00 цагийн хооронд хязгаарлан явуулбал зохих ба энэ хоёр хугацааны аль хатууг баримтлан явуулбал зохино. Хэрэв эдгээр цаг хугацааны хязгаарлалтуудаас гадна ямарваа ажил гүйцэтгэх шаардлагатай болвол: (a) зохих эрх бүхий байгууллагаас заавал зөвшөөрөл авсан байх ба (b) орон нутгийн иргэдэд хангалттай хугацааны өмнө урьдчилж мэдэгдсэн байна. |
| Хатуу хог хаягдал | Гүйцэтгэгч нь ажлын бүх газарт үүссэн хаягдал материал (хуучин тоолуур, баглаа боодол, хаягдал утасны тасархай г.м)-ыг цуглуулах ба БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний зөвшөөрсөн зориулалтын газар түр хадгална.<br>Хатуу хог хаягдлыг шатааж, талбар дээр булж эсвэл хаяж үл болно.<br>Ашиглалтын хугацаа нь дуусаагүй тоолуурыг шаардлагатай бол БЗӨБЦТС/ ЭБЦТС-ний бусад талбаруудад хадгалах ба/буюу ашиглана.<br>Өөр байдлаар ашиглагдах боломжгүй хаягдал материалыг цуглуулан хадгалж, дахин боловсруулах/засварлах эрх бүхий байгууллагад худалдан борлуулна.<br>Гүйцэтгэгч нь ямар ч тохиолдолд байгалийн амьдрах орчин буюу усны голдрил гэх мэт байгаль орчны хувьд эмзэг газруудад ямарваа эд материалыг хаяж үл болно.<br>Ажлын талбараас зайлуулсан хатуу хог хаягдал буюу барилгын хаягдлыг зөвхөн орон нутгийн хог хаягдлын удирдлагын эрх бүхий байгууллагын заасан, албан ёсны зориулалтын газарт хаяна. |
| Нийтийн аж ахуйн үйлчилгээний тасалдал | Өртсөн өрхүүдэд ажлын хуваарь болон цахилгаан тасалдах төлөвлөгөөний талаарх мэдээллийг хамгийн багадаа 2 хоногийн өмнө өгнө.<br>Одоо ашиглагдаж буй кабел, харилцаа холбооны шугам зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээний шугамд гарсан ямар нэгэн гэмтлийг эрх бүхий байгууллагад мэдээлэн, аль болох хурдан засварлана. Гүйцэтгэгч нь холбогдох зардлыг хариуцна. (ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БАРИМТ БИЧИГТ ОРУУЛАХ) |
| Нүүдлийн болон газар үүрээ засдаг шувууд | Нүүдлийн: Нарны хавтан болон дамжуулалтын шугамтай мөргөлдөх<br><br>Газарт үүрээ засдаг: Газарт үүрээ засдаг хэлбэр байдлыг алдагдуулах | ШМТ-ний дагуу | | | | Төслийн спонсортой хамтран ажиллах орон нутгийн ТББ-ын хамт дотоодын шувууны эксперт |

| Ашиглалтаас гаргах | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хаягдал зайлуулалт | Дахин ашиглах боломжтой материалыг зохих байдлаар зайлуулсан уу?<br><br>Дахин ашиглах боломжгүй материалууд ыг засгийн газрын зөвшөөрсөн хаягдал зайлуулах цэгт өгсөн үү? | Ачилтын цэг дээр<br><br>Хаягдал зайлуулах цэг | Харагдах боломжтой<br><br>Харагдах боломжтой | Ашиглалтаас гаргах үйл ажиллагааны үеэр ба уг үйл ажиллагаа дуусгавар болтол<br><br>Ашиглалтаас гаргах үйл ажиллагааны үеэр ба уг үйл ажиллагаа дуусгавар болтол | Бага<br><br>Бага | Төслийн спонсор<br><br>Төслийн спонсор |
| Газрын гадаргууг сэргээх | Станцийн талбарыг өмнөх газрын хэлбэртэй аль болох адилхан байдлаар сэргээвэл зохино<br><br>Станцийн талбарыг тухайн газар өмнө оршиж байсан төрөлтэй ижил буюу адилтгах төрлийн уугуул ургамлаар дахин ургамалжуул сан | Станцийн талбар дээр<br><br>Станцийн талбар дээр | Харагдах боломжтой<br><br>Харагдах боломжтой | Нарны эрчим хүчний станцийн тоног төхөөрөмж ба байгууламжий г зайлуулсан дараагаар<br><br>Станцийн талбарын газрын гадаргууны хэлбэр байдлыг дахин сэргээсний дараагаар | [тодорхойло гдоно]<br><br>[Тодорхойло гдоно] | Төслийн спонсор<br><br>Дотоодын ургамал судлалын эксперт ашиглахыг зөвлөх |

## ХАВСРАЛТ В    НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХҮРЭЭ

### В 1. Танилцуулга

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд хэрэгжих дэд төслүүдийн хөрөнгө оруулалтын ажлын нарийн байршил болон төрөл, инженерчлэлийн ажлын нарийн загвар, дэд бүтцийн ажлын нарийн талбар байршил тодорхой болоогүй байна. Байршлын талаар шийдвэрийг инженерчлэл болон бусад хэрэгцээ шаардлага мөн оролцогч талууд болон аливаа өртсөн иргэд (ӨИ)[6]-тэй хийсэн эхний зөвлөлдөх хэлэлцүүлгийн санал зэргийг харгалзан гаргана. Нарны цахилгаан станцийн цаашид хөгжүүлэх ямарваа байршил (Бүрэлдэхүүн хэсэг 2) мөн адил хараахан тодорхой болоогүй байгаа ба улмаар Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээ (НШБХ)-г нийгмийн хамгааллын зохих баримт бичиг гэж сонгосон болно.

Энэхүү төсөл нь хамгааллын Б ангилалд хамаарах учир ихээхэн хэмжээний нүүлгэн шилжүүлэлтийн хэрэгцээ, шаардлага гарна гэж урьдчилан тооцоолоогүй ба ямар нэгэн биет шилжин суурьшилтыг урьдчилж тооцоолоогүй болно. Бүрэлдэхүүн хэсэг 2 нь төрийн эзэмшлийн газар дээр байршин, албадан нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийнэ гэж тооцоолж байгаа болно. Төрийн эзэмшлийн газар ашиглах боломжгүй тохиолдолд энэхүү НШБХ нь зааварчилгаагаар хангана.

Энэхүү НШБХ нь  (i) зөвхөн Бүрэлдэхүүн хэсэг 1-т зориулсан нөлөөлөл бага, амьжиргаанд нөлөөлөхгүй ба нөхөн олговор шаардлагагүй сайн дурын хандивлалтын журам; ба (ii) барилгын ажлыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө дэд төслүүдийн дэлгэрэнгүй төлөвлөлтийн шатанд дуусгавар болох Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ)/буюу Нүүлгэн шилжүүлэлтийн товч төлөвлөгөө (НШТТ)-г боловсруулахад хүргэх урьдаас төлөвлөгдөөгүй нөлөөллийн талаар баримтлах бодлого журмыг тус тус танилцуулав.

НШТ-г Дэлхийн Банкны Үйл ажиллагааны бодлого 4.12. Албадан нүүлгэн шилжүүлэлт, Хавсралт А-гийн 1-21 дүгээр зүйлд нийцүүлэн бэлтгэнэ. Хэрэв нүүлгэн шилжүүлэлтэнд 200-гаас цөөн тооны хүн өртөх бол нөлөөлөл нь бага хэмжээний байх ба Үйл ажиллагааны бодлого 4.12, Хавсралт А-гийн 22 дугаар зүйлийн дагуу НШТТ-г боловсруулна. НШТ буюу НШТТ нь Дэлхийн Банк болон Зээлдэгч нарын хоорондын гэрээний нэг хэсэг болно. Нүүлгэн шилжүүлэлтийн аль ч баримт бичиг сонгогдсон бай товчлох зорилгоор энэхүү баримт бичигт “НШТ” гэдэг нэршлийг ашиглана.

ТУН нь энэхүү НШБХ-ны зарчмуудтай нийцүүлэн газар буюу амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон хариу арга хэмжээний ерөнхий үнэлгээг төслийн төлөвлөлтийн явцтай зэрэгцэн (БОНУХ-ний 6.2 Ерөнхий үнэлгээ ба ангилал хэсэг болон ерөнхий үнэлгээний хэрэгслийн талаарх Хавсралт В 15-аас үзнэ үү) ТХН-үүдтэй хамтран гүйцэтгэх үүрэг бүхий хүмүүсийг оролцуулна.

### В 2. Зорилго ба үндсэн зарчим

Уг НШБХ нь Монгол Улсын хууль болон Дэлхийн Банкны Үйл ажиллагааны бодлого 4.12 болох албадан нүүлгэн шилжүүлэлтийн шаардлагуудыг тусгасан. НШБХ-ний баримтлах зарчим нь төслийн туршид албадан нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх эсвэл түүнийг хамгийн бага байлгах явдал юм. Бодлогын зорилго нь зайлсхийх боломжгүй нөхцөлд үр нөлөөллийг хамгийн бага байлгахад оршино. Эцсийн дүнд НӨИ нь төсөл эхлэхийн өмнөхөөс илүү сайн нөхцөлд байдал байх эсвэл ижил түвшний нөхцөл байдал байвал зохино. Төслийн нөлөөлөлд өртөх бүх иргэдтэй төслийн явцын туршид зөвлөлдөн, төлөвлөлтөд оролцох болон төслийн үр шимийг хүртэх боломжоор хангана. Уг төсөл нь тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах ёстой.

Эдгээр зарчмууд нь оролцогч талууд болон нэн ялангуяа НӨИ-ийг эрт тодорхой болгох; ямарваа мэдэгдэж

[6] Дэлхийн Банкны Үйл ажиллагааны бодлого 4.12-д “шилжин суурьшсан” гэдэг нэр томъёог өртсөн хүмүүсийн нийгэм ба/буюу эдийн засгийн мөн биет шилжилт хөдөлгөөнийг илэрхийлэхэд ашигладаг. Энэхүү баримт бичигт төөрөгдөл үүсэхээс сэргийлэх зорилгоор “өртсөн” гэдэг үгийг ямарваа сөрөг нөлөөлөлд автсан хүнийг илэрхийлэхэд ашиглана.

байгаа нөлөөллийн талаар олон нийтэд үр дүнтэй мэдээлэх; тогтоогдсон сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсвэл түүнийг багасгах болон ямарваа нэгэн хувь хүн эсвэл нөлөөллийг орхигдуулахгүй байх тулд нийгмийн бүх салбартай зөвлөлдөх ба хамтран ажиллах; хэрэгжилт, нүүлгэн шилжүүлэлт, амьжиргааг дахин сэргээх явцад НӨИ-ийг дэмжих үүднээс шударга, ил тод, цаг тухайд нь арга хэмжээ авах; мөн ялангуяа ядуурал, гарал угсаа, хүйс, нас, хөгжлийн бэрхшээл эсвэл нийгмийн байдлаасаа шалтгаалж өртөмхий байх боломжтой иргэдийн амьжиргааны нөхцлийг сайжруулах эрмэлзэл зэргийг шаардана.

Хэрэв газар болон үл хөдлөх хөрөнгө алдагдсан бол ижилхэнээр сольж өгөх, боломжгүй тохиолдолд алдагдсан газар, хөрөнгө, орлогод нөхөн олговор олгох болон шинээр суурьшин, амьжиргаагаа дахин сэргээх зардлыг хариуцахыг зорино. Дахин сэргээлтэд зөвхөн биет хөрөнгөөр зогсохгүй нийгмийн болон соёлын хөрөнгө багтана. Эмэгтэйчүүдэд зонхилон тулгардаг эдгээр үнэт зүйлсийг сүйтгэх эрсдэл бий бол ӨИ нь бодлогын зорилгыг хангахын тулд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон нүүлгэн шилжүүлэлтийн хувилбаруудыг сонгох явцад оролцоно.

## В 3. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлтийн үндсэн зарчмууд

Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт болон хэрэгжүүлэлтийн явцад дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

- Газар чөлөөлөхөөс зайлсхийх буюу газар чөлөөлөлтийг аль болох хамгийн бага байлгавал зохино. Хэрэв зайлсхийх боломжгүй бол дэд төслийн төлөвлөгөө болон НШТ-г шилжин суурьшсан хүн ам нь төслийн үйл ажиллагаанаас бий болсон үйлчилгээ, байгууламжийн үр ашгийг хүртэх боломжтой байхаар хөгжлийн боломж болгон боловсруулвал зохино.
- Шилжин суурьшсан бүх хүн төслөөс болж алдсан орлого, газар, эд хөрөнгөний нөхөн олговор эсвэл нөхөн төлбөрийн оронд нөхөн төлбөртэй тэнцэх хэмжээний өөр төрлийн тусламж авах эрхтэй. Алдсан хөрөнгө нь хуулиар хамгаалагдаагүй байгаа нь шилжин суурьшсан хүний нөхөн олговор эсвэл өөр төрлийн тусламж авах эрхэд саад болохгүй.
- НШТ-нд тусгасан нөхөн олговрын хэмжээ нь алдсан зохих хөрөнгөний эзэн эсвэл хэрэглэгчид ямар нэгэн элэгдэл, хасалтгүйгээр бүрнээр нь төлөх дүнг хэлнэ.
- Тариалангийн газар чөлөөлүүлэх үед хэрэв шилжин суурьшсан хүн хүсвэл төсөл хэрэгжүүлэгч/Банкнаас зээлдэгч газрыг газраар солих арга замыг хайвал зохино.
- Газар, хураагаагүй тариа, эд хөрөнгийн нөхөн төлбөрийг төсөл нөлөөлж эхлэхээс өмнө төлвөл зохино.
- Зөвхөн Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хөрөнгө оруулалтанд зориулан газар хандивлалтыг зөвхөн бүрэн баримтжуулагдсан ба Сайн дурын хандивын талаар зааварчилгаатай бүрэн нийцэж байгаа тохиолдолд зөвшөөрөгдөнө (В 5 хэсгээс үзнэ үү)
- Шилжин суурьшсан хүмүүсийн газар чөлөөлөх ба нөхөн төлбөрийн асуудалтай холбоотой санал хүсэлтийг авч тусгахын тулд НШТ-ийн бэлтгэл ажил хийгдэх үед тэдэнтэй зөвлөлдөх хэрэгтэй.
- Төслийн талаар мэдээлэл болон НШТ-ийн төсөл ба эцсийн хувилбарыг шилжин суурьшсан хүмүүст хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэнэ. Эдгээр мэдээлэл нь Засгийн газрын болон Банкны вэб сайтууд дээр байх бөгөөд холбогдох Засгийн газрын агентлаг ба үйлчилгээний компанид мөн хэвлэгдсэн хуулбараар байх болно.
- Газар чөлөөлсөний дараа орон нутгийн үйлчилгээ ба нөөцөд хандах боломж нь өмнөх түвшинд байх эсвэл сайжирсан байх болно. Хэрэв хувь хүмүүс эсвэл ард иргэд шилжин суурьших ёстой бол тэдний өмнө эдэлж байсан үйлчилгээтэй ижил түвшний эсвэл сайжирсан үйлчилгээг тэдэнд, шилжин очсон газар өмнө байрлаж байсан иргэдэд хүргэх ёстой.
- Төслийг хэрэгжүүлэгч/Банкнаас зээлдэгч газар чөлөөлөх болон нөхөн төлбөртэй холбоотой зардлыг гаргах үүрэгтэй. Аливаа бэлтгэсэн НШТ нь тооцоолоогүй зардлыг оруулан газар чөлөөлөхтэй холбоотой бүх зардлын тооцоолсон төсвийг агуулсан байна.

- Шаардлагатай тохиолдолд шилжин суурьшсан хүмүүс гомдол гаргах, гаргасан гомдлын дагуу шалгах арга замыг бий болгох бөгөөд энэүү гаргасан гомдлын дагуу шалгах журмын талаарх мэдээллийг шилжин суурьшсан хүмүүс болон зарим тав тухгүй байдалд орж болох ард нийтэд хүргэнэ.
- Нээлттэй зах зээлийн газар худалдан авалт нь сайн дурын, баримтжуулсан, өрсөлдөх нэхэмжлэл байхгүй эсвэл хүндрэл төвөггүй байх ёстой.

## В 4. Эрх зүй, зохицуулалтын орчин

Энэхүү НШБХ-ний бүх заалт нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж (дор жагсаасан) болон Дэлхийн Банкны Үйл ажиллагааны бодлого 4.12. Албадан нүүлгэн шилжүүлэлттэй нийцэж байгаа болно. Үндэсний хууль тогтоомж болон Дэлхийн Банкны бодлогын холбогдох заалтуудыг энэ хэсэгт аливаа зөрүүтэй байдлыг арилгах арга хэмжээний хамт тоймлон үзүүлэв.

Одоогийн эрх зүйн орчинд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэнд хамаарах үндсэн хууль тогтоомжид дараах орно:

- Үндсэн хууль (1992 он)
- Газрын тухай хууль (2006 он)
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003 он)
- Иргэний хууль (2002 он)
- Засгийн газраас гаргасан газрын үнэлгээний тариф (Засгийн газрын 103-р тогтоол, 2003 он)
- Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2003 он)

Монгол Улсын Үндсэн хуулинд “төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно”, мөн “төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” хэмээн тус тус тухайлан заасан байдаг.

Газрын тухай хуулиар газар эзэмших эрх дуусахад газрыг хэрхэн чөлөөлөхийг зохицуулдаг. Газар эзэмшлийн эрхгүй эзэмшигчийг хууль бус газар ашиглагч гэж үздэг ба “хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй газар эзэмшихийг хориглоно” гэж заасан Газрын тухай хуулийн 27.4 дүгээр заалтын дагуу албадан нүүлгэх боломжтой. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулинд хувийн өмчлөлд буй газрыг албадан чөлөөлөхтэй хамаарах заалтууд байдаг. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд уг хуулийн 35-р зүйлд иргэний өмчийн газрыг хураах талаар зохицуулсан байдаг. Засгийн газрын газар үнэлгээний тарифаар (Засгийн газрын 103 дугаар тогтоол) газрын үнэлгээг тогтоодог.

Төсөл нь Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн хүрээнд “улсын чанартай зам, шугам сүлжээ, бусад объектийг барих” (32.1.3)-д хамааруулан иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авч болно. Доорх Хүснэгт В01-т Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу болон Дэлхийн Банкнаас тавигдах шаардлагуудыг харьцуулан, тэдгээрийн хоорондын ялгааг хамт үзүүлэв.

Хүснэгт В01: Монгол Улсын хууль тогтоомж болон Дэлхийн Банкны албадан нүүлгэн шилжүүлэлтийн талаар баримтлах шаардлагуудын харьцуулалт

| **Сэдэв** | **Монгол Улсын хууль тогтоомжийн заалтууд** | **Дэлхийн Банкны шаардлагууд** |
|---|---|---|
| Албадан нүүлгэн шилжүүлэлт | Барилга байгууламж барихад иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх | Төрийн хэрэгцээнд хувийн өмчийг нөхөн олговортойгоор хураан авах |

| | | |
|---|---|---|
| | олговортойгоор эргүүлэн авахад нийтийн хэрэгцээнд зориулан иргэний өмчийг авах төрийн эрх хэрэгжүүлэхийг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрнө. (Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 32 ба 37 дугаар зүйл; Газрын тухай хууль, 42 ба 43 дугаар зүйл). Уг хууль нь тус төсөлд хамаарна. | улсын эрхийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг ба газар чөлөөлөх, алдсан үл хөдлөх хөрөнгийг солих болон алдсан амьжиргааг сэргээх үйл ажиллагаанаас зайлсхийх мөн хамгийн бага хэмжээнд байлгахад чиглэсэн бодлогын заалтуудыг мөрдөнө. Өртсөн этгээд нь дор хаяж төслийн өмнөх үеийн нөхцөлд байх. |
| Хэлэлцсэн тохиролцоо/ нээлттэй зах зээлийн худалдан авалт | Монгол Улсын Иргэний хууль нь өртсөн этгээдээс төр рүү газар шилжүүлэх гэрээний эрх зүйн суурь болдог. (15 дугаар бүлэг, 1, 6, 7, 8, 109 ба 112 дугаар зүйл, ба бусад). | Сайн дурын худалдан авагч болон сайн дурын худалдагч нар байгаа тохиолдолд нээлттэй зах зээлийн худалдан авалтыг хүлээн зөвшөөрдөг. Хэрэв тухайн худалдагчид өөр сонголт байхгүй бол ҮАБ 4.12-ын шаардлагуудыг мөрдөнө. |
| Өртсөн этгээдэд хамаарвал зохих этгээдүүд | Гэрчилгээ бүхий газрын өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид нь Газрын тухай хууль (35 ба 38 дугаар зүйл) болон Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (27 дугаар зүйл)-ийн хүрээнд хүлээн зөвшөөрсний дагуу өөрсдийн эрхийг бусад хуулийн этгээдэд шилжүүлэх боломжтой.<br>Хууль бус эзэмшигчид болох газар эзэмшлийн эрхгүй эзэмшигчид нь эзэмшиж буй газраа шилжүүлэх буюу нөхөн олговор авах эрхгүй (Газрын тухай хууль, 27.4 дүгээр заалт).<br>Иргэний хуулиар улсын бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд өмчлөгчгүй үл хөдлөх хөрөнгө (газрыг оролцуулан)-ийн урт хугацааны өмчлөгч бус эзэмшигчийн өмчлөх эрхийг 15 жилийн дараагаар хүлээн зөвшөөрдөг (104.2). | Эрх бүхий өртсөн этгээд нь өртсөн газар болон газар биш үл хөдлөх хөрөнгөө орлуулах өртгөөр нөхөн олговор авах, сэргээн олж авах эрхтэй байна.<br>Өртсөн газарт хууль ёсны эрх үүсээгүй хүмүүс нь барилга байгууламжийнхаа нөхөн олговорыг авах боломжтой ба нүүлгэн шилжүүлэлт болон сэргээх босгох бусад туслалцааг авах эрхтэй байж болно. |
| Газрын нөхөн олговор | Нөхөн олговор нь төр рүү шилжүүлсэн газрын гэрээгээр тохиролцсон төлбөр юм. Тус улсын практикт Засгийн газрын газар үнэлгээний тариф (Засгийн газрын 103 дугаар тогтоол, 2003 он)-ийг ашигладаг боловч өртсөн этгээдүүдтэй мөн тохиролцоо хийдэг. Өртсөн этгээдийн газрыг бүхэлд эсвэл ихээхэн хэсгийг чөлөөлөх тохиолдолд орлуулах газрыг олгох нь бий. | ҮАБ 4.12-т амьжиргааг нөхөн сэргээх зорилгоор сэргээн босгох арга хэмжээнүүдийн хамт газрыг шууд орлуулан өгөх эсвэл орлуулах зардлыг өгөхийг заасан байдаг.<br>Нөхөн олговорыг нөлөөлөл үзүүлэх хугацаанаас өмнө төлвөл зохино. |
| Барилга байгууламжийн нөхөн олговор | Чөлөөлсөн газар дээр байрлах барилга байгууламжийг шилжүүлэхэд зориулсан гэрээгээр тохиролцсон төлбөр. Тухай барилга байгууламжийн нийт өртгөөс элэгдлийг хасан, барилга байгууламжийн үнийг зах зээлийн үнээр тогтоодог. | Байшин болон бусад барилгын хувьд нөхөн олговор нь орлуулах зардал байна. Энэ нь өртсөн барилга байгууламжтай ижил эсвэл илүү их хэмжээ, чанар бүхий орлуулах барилга байгууламжийг барих материалын эсвэл хагас өртсөн барилга байгууламжийг засах зах зээлийн өртөг байх ба дээр нь барилгын ажлын талбай руу барилгын материал зөөх өртөг, ямарваа ажиллах хүчин эсвэл гүйцэтгэгчийн төлбөрийн зардал мөн ямарваа бүртгэл, шилжүүлгийн татвар хураамжийн зардал орно. |
| Дундын өмчийн хөрөнгө | Иргэний хуулиар дундын өмчийн хөрөнгө болон гэр бүлийн хөрөнгийн эрхийг хүлээн зөвшөөрдөг (108 ба 125-128 дугаар зүйл).<br>Дундын өмчийн хөрөнгө нь тухайн өмчийн хэсгийг бусад өмчлөгчдийн зөвшөөрлөөр захиран зарцуулахыг шаарддаг (108.4).<br>Гэр бүлийн хөрөнгөд 'гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл | Дэлхийн Банкны шаардлагуудтай зөрчилдөхгүй хэдий ч хамтын гарын үсгийг дэмжинэ. |

| | | |
|---|---|---|
| | шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө’ орно (126.2.4). Гэр бүлийн үл хөдлөх хөрөнгө (газрыг оролцуулан)-ийг харилцан тохиролцсоны үндсэн дээр (128.1), гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлөөр (128.2) захиран зарцуулах шаардлагатай. | |
| Өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх (өмчийн сервитут) | Өөр хүний өмч хөрөнгийг ашиглах нөхцлийг бүрдүүлдэг бусдын өмчийг ашиглах эрх (easement)-ийн талаарх хуулийн заалт Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 33-р зүйлд заасны дагуу хэрэгжинэ. | Дэлхийн Банкны шаардлагуудтай зөрчилдөхгүй. |
| Газар буюу байшингийн түрээс | Иргэний хуулийн 25 дугаар бүлэгт газар ба байшин зэрэг эд хөрөнгийн түрээсийг зохицуулдаг. Хэрэв шинэ өмчлөгчид эд хөрөнгийг шилжүүлсэн бол тухайн шинэ өмчлөгч хөлслүүлэгчийн бүх эрх, үүргийг хариуцна (297 дугаар зүйл). Түрээсийг цуцлах 3 сарын хугацаатай мэдэгдэл өгөх шаардлагатай (294.3 дугаар заалт)-г эс тооцвол төсөлд зориулан газар чөлөөлөх тохиолдолд хөлслөгчийн эрхийн талаарх заалт байхгүй. | Түрээс, лизингээр дамжуулан сайн дурын түр хугацаанд ашиглах боломжийг олж авах боломжтой. Ямарваа түр хугацааны албадан чөлөөлөлтийг аль болох бага хэмжээтэй байлгах ёстой ба төслийн төлөвлөгөөнд ямарваа түр хугацааны албадан чөлөөлөлтийн нөхөн олговрыг оруулах ёстой. Банкны төслөөс шууд шалтгаалан түр хугацааны чөлөөлөлтийн зардлыг сайн дурын бусаар үүрч буй иргэдийг НШХ гэж үзнэ. |
| Орон нутгийн иргэд болон нийтийн нөөцийг алдах | Өртсөн орон нутгийн иргэд болон нийтийн хөрөнгийг Иргэний хуулийн хүрээнд гэрээний дагуу шилжүүлэх боломжтой. Өртсөн барилга байгууламжийг нүүлгэх зардлыг төслийн барилгын ажлын зардалд хамруулна. | Газар чөлөөлөлтөд өртсөн нийтийн хөрөнгийн нөөц эсвэл олон нийтийн барилга байгууламж болон дэд бүтцэд нөхөн олговор олгож болно. |
| Орлого ба амьжиргааг нөхөн сэргээх | Өмчийг шилжүүлэх гэрээний тохиролцооны ямар нэгэн заалт байхгүй. | Нүүн шилжсэн хүмүүст нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх түвшин буюу төслийн хэрэгжилтийн өмнө зонхилж байсан түвшин буюу эдгээрийн аль илүү түвшинд амьжиргаа болон амьдралын түвшингөө сайжруулах эсвэл ядаж нөхөн сэргээх хүчин чармайлтанд нь бодит байдлаар туслах ёстой. |
| Шилжин суурьших ба шилжүүлгийн (transaction) зардлууд | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар өмчийн эрхийн улсын бүртгэл хариуцсан Төрийн захиргааны байгууллагад үл хөдлөх эд хөрөнгийг бүртгүүлэхэд зориулан бүртгэлийн тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлсийг төлөх шаардлагатай (9 дүгээр зүйл). Аливаа бүртгэл ба бусад төлбөр мөн шилжин суурьших зардал нь гэрээний талуудын үүрэг бөгөөд гэрээнд тусгагдаж болно. | Аливаа захиргааны төлбөр хураамж, эрхийн төлбөр эсвэл хууль эрх зүйн бусад шилжүүлгийн зардлыг төслөөс төлөх буюу чөлөөлөх ёстой. Ямарваа бүртгэл болон шилжүүлгийн татвар хураамжийн зардал, хөдөө орон нутаг эвсэл хот суурин газар дах газар эсвэл байшин эсвэл өөр барилга байгууламжийн аль ч байсан орлуулах зардлын тооцоонд багтана. Хэрэв нөлөөлөлд биет нүүн шилжилт хамрах бол нүүн шилжих үеэр туслалцаа (нүүх тэтгэмж зэрэг) үзүүлнэ. |
| Гомдол гаргах журам | Газрын тухай хуулинд газрын талаарх маргааныг засаг захиргааны нэгжийн засаг дарга нар болон цаашлаад шүүхээр шийдвэрлүүлэхээр заасан байдаг (60 дугаар зүйл). Иргэний тухай хууль болон Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулинд олон төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр заасан байдаг. | Нүүн суурьшсан хүмүүс болон тэдгээрийн бүлэгт тохиромжтой бөгөөд хүртээмжтэй гомдол шийдвэрлэх тогтолцоог бий болгоно. |

| | | |
|---|---|---|
| Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний мэдээллийг нийтэд мэдээлэх ба олон нийтийн зөвөлгөөн | Олон нийттэй зөвлөлдөх болон мэдээлэл өгөх заалт байхгүй. Практикт бүх тохиолдол хэлцэл хийх цаг хугацаанд хамаардаг. | ҮАБ 4.12-т нийцсэн нүүлгэн шилжүүлэлтийн баримт бичгийн төслийг нүүн шилжих иргэд ба орон нутгийн ТББ-д хүртээмжтэй газар, тэдгээрт ойлгомжтой хэлбэр, байдал, хэл дээр танилцах боломжтой байна. Нүүн шилжих иргэдтэй бодитой зөвлөлдөх ёстой ба нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэнд оролцох боломжтой байна. |
| Тасалбар болгох хугацаа | Хамаарахгүй | Ерөнхийдөө энэхүү тасалбар болох хугацаа нь тооллого эхлэсэн огноо болно. Тасалбар болох хугацаа нь мөн тооллогын өмнө төслийн байршлыг хүрээлэн татсан хугацаа байж болно. Ингэхдээ хүрээлэн татсан төслийн газрын талаарх мэдээлийг үр дүнтэйгээр олон нийтэд түгээн, цаашид хүн амын шилжилт хөдөлгөөнөөс сэргийлэх зорилгоор хүрээлэн татсны дараагаар зохион байгуулалттайгаар болон тасралтгүй мэдээлэл түгээсэн тохиолдолд болно. |
| Өмчийг чөлөөлөх ба барилгын ажлыг эхлүүлэх мэдэгдлийн хугацаа | Тухайн өмчийг чөлөөлөх цаг хугацааг гэрээнд зааж өгч болно.<br>Барилгын ажлыг тодорхой заасан хүлээх хугацаагүйгээр өмчийг чөлөөлөхтэй зэрэгцэн эхлүүлдэг. | Нүүлгэн шилжүүлэлт эсвэл барилгын ажлыг эхлүүлэхийн өмнө мөнгөн нөхөн олговорыг олгоно. |

Хүснэгт B01-т үзүүлсний дагуу Монгол Улсын хууль эрх зүйн тогтолцоо болон Дэлхийн Банкны Үйл ажиллагааны бодлогын хооронд хэд хэдэн бодлогын зөрүү байгаа болно. Монгол Улсын хууль тогтоомж, практикийн дагуу: (i) газар ба барилга байгууламж түрээслэгчийг оролцуулан газар эзэмшлийн эрхгүй (өмчлөх буюу эзэмших гэрчилгээгүй) оршин суугч нь нөхөн олговор болон сэргээн босголтын эрх эдэлдэггүй; (ii) ӨИ тус бүртэй хэлэлцээ хийх боломжтой хэдий ч өртсөн газарт олгох нөхөн олговор зах зээлийн үнэ ханшинд бус засгийн газрын үнэнд суурилдаг; (iii) өртсөн барилга, байгууламжийг үнэлэхэд элэгдлийн коеффициент ашигладаг; (iv) орон нутгийн газар чөлөөлөлтийн практикт орлого ба амьжиргааг сэргээх асуудлыг ерөнхийдөө авч үздэггүй; (v) нөхөн олговорын төлбөрт шилжүүлгийн зардал ордоггүй; (vi) засаг дарга болон шүүхээр маргаан шийдвэрлүүлэхийн өмнө төслийн дотоод гомдол шийдвэрлэх журам байдаггүй; (vii) олон нийттэй зөвлөлдөх мөн мэдээлэл танилцуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэггүй; (viii) эрх үүсэхэд зориулсан тасалбар болгох огноог мэдээлдэггүй; (ix) газар чөлөөлөлтийн бүх журмыг биелүүлж дууссаны дараагаар барилгын ажил эхлүүлэх хязгаарлалт байдаггүй; (x) НШТ боловсруулах эсвэл мониторинг, үнэлгээний арга хэмжээ авах шаардлага байдаггүй. Эдгээр зөрүүг арилгахын тулд энэхүү НШБХ-нд аль алиныг нэгтэсэн, ингэхдээ зөрүүтэй тохиолдолд Дэлхийн Банкны бодлогын шаардлагууд давамгайлсан эрхийн заалтууд (ХВ15 бүлгийн Эрхийн матриксийг үзнэ үү)-ыг оруулав. Энэхүү төсөлд зориулан бэлтгэсэн ямарваа НШТ-гөөр дэд төслийн нөлөөлөлд хамааруулан Эрхийн матриксийг шинэчилнэ. Түүнчлэн, процесстой холбоотой зөрүү (тухайлбал, НШТ бэлтгэх, гомдлын журам, зөвлөлдөх хэлэлцүүлэг ба тасалбар болох хугацаа)-г арилгахын тулд В3 хэсэгт тоймлон үзүүлсэн нүүлгэн шилжүүлэлт төлөвлөлтийн үндсэн зарчмуудыг  энэхүү төсөлд мөрдөнө.

## B 5. Сайн дурын газар хандивлалтын тогтолцоо ба баримтжуулалт

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хөрөнгө оруулалтанд зориулан бага хэмжээний барилгын ажилд зориулан нээлттэй зах зээлээр дамжуулан газар худалдан авах эсвэл сайн дурын хандивлалтыг эрэлхийлэх тохиолдолд гарч болзошгүй юм. Сайн дурын газар хандивлалт гэдэг нь хувь хүн буюу орон нутгийн нэгжийн эзэн газар эсвэл өмчийг төсөлтэй холбоотой үйл ажиллагаанд зориулан өгөх ажиллагааг хэлнэ. Ерөнхийдөө сайн дурын

газар хандивлалтыг нөхөн олговоргүйгээр зохион байгуулдаг. Сайн дурын хандивлалт гэдэг нь тухайн газрыг хандивлах буюу шилжүүлэхгүй байх эрх зэрэг бусад сонголт ба тэдгээрийн үр дагаварыг урьдчилан мэдэж хийсэн, бүрэн мэдээлэл авсны үндсэн дээр зөвшөөрөх үйлдэл болно.

Дэлхийн Банкны хамгааллын бодлогод нийцэхийн тулд төсөлд зориулан газар буюу түрээсийн эрхийн ямарваа хандивлалт нь дараах зарчмуудтай нийцсэн байна:

- Хандивлагч нь шугам сүлжээнд холбогдсон байвал зохих буюу газар хандивлахын өмнө буюу хандивласан даруй холбогдсон байвал зохино.
- Аливаа боломжит хандивлагч нь төслөөс шууд үр өгөөжийг хүртвэл зохино.
- Хандивлалтыг тодорхой зорилго, хугацаатай хийнэ. Тухайн газрыг хугацаагүйгээр хандивлаагүй бол хандивлалтын гэрээнд хугацааны дуусгавар болоход тухайн газрыг хэрхэх талаар заана.
- Боломжит хандивлагч нь татгалзах хувилбар байгааг мэдсэн байх ба хандивлагчийн гарын үсэг зурах хандивлалтын баримт бичигт татгалзах эрхийн талаар тусгасан байна.
- Хандивлалтын үйлдэлийг төрийн буюу уламжлалт эрх бүхий байгууллага, хүмүүсийн зүгээс шахалт, ов мэх эсвэл ямар нэгэн хэлбэрийн дарамтаас ангид гүйцэтгэнэ. Үүнийг нь хөндлөнгөөс ТУН эсвэл орон нутгийн ТББ гэх мэт бие даасан гуравдагч этгээд баталгаажуулна. Хандивлагчтай хийсэн зөвлөлдөх уулзалтын тэмдэглэлд баталгаажуулалт шаардлагатай.
- Хандивлагч нь хандивлалтын нөхцөл болгон нөхөн олговор (бүтэн эсвэл хэсэг) эсхүл өөр хэлбэрийн тэтгэмж авахаар хэлэлцээ хийж болно.
- Хандивлаж болох газрын хэмжээ тухайн боломжит хандивлагчийн газрын хэмжээний 10 хувийг хэтэрч үл болно.
- Хэрэв ямар нэгэн өрхийг албадан нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болохоор бол газар хандивлалтыг хийж болохгүй.
- Нийтийн эзэмшлийн буюу орон нутгийн газрын хувьд тухайн газрыг ашиглаж буюу эзэмшиж буй эсхүл уламжлалын дагуу зарим эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн бүх хувь хүмүүсийн зөвшөөрлөөр зөвхөн хандивлалтыг гүйцэтгэж болно.
- ТУН нь тухайн газар дээр ямар нэгэн ажил эхлэхийн өмнө хандивлах гэж буй газар нь ямар нэгэн бэрхшээл эсвэл зөрчилгүйг баталгаажуулна.
- Тохиролцсон зориулалтаар төслөөс ашиглаагүй ямарваа хандивласан газрыг хандивлагчид буцаан өгнө.

Эдгээр нөхцлүүдийн зорилго нь хууль эрх зүйн ямар нэгэн саад тотгор буюу хойшлуулалтгүйгээр шинэ эзэмшигч буюу түрээслэгч тухайн газартай холбоотойгоор хууль ёсны ямар нэгэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой байлгахад оршино. Төсөл хэрэгжилт болон газар бүртгэл хариуцсан байгууллагууд нь газар хандивлалтын тохиолдол тус бүрийг баримтжуулсан бүртгэлийг хөтлөн, үүсч болох аливаа гомдолд зориулан уг баримтжуулалтыг хянах боломжтой байлгах мөн сайн дурын газар хандивласан, Дэлхийн Банктай хамтарсан аливаа төсөлд зориулан хүсэлт гаргавал Дэлхийн Банкийг тухайн баримтжуулалтыг ашиглах боломжоор хангана. Мөн ХВ15 хэсэгт сайн дурын зөвшөөрлийн маягтын загварыг үзүүлэв.

## В 6. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг бэлтгэх ба батлах

НШТ-үүдийг бэлтгэх үйл ажиллагааг төслийн ямар нэгэн үйл ажиллагааг гүйцэтгэхэд газар чөлөөлөлт нэн шаардлагатай болох нь тогтоогдож, ерөнхий үнэлгээний явцуудаар (тус БОНУХ-ний Ерөнхий үнэлгээ ба ангиллын 6.2 хэсгийг үзнэ үү) чөлөөлөх газрын хэмжээг тогтоож өгмөгц эхэлнэ. ТУН нь дараах байдлаар НШТ-г бэлтгэн, хэрэгжүүлнэ:

- Төсөлд төрийн байгууллагуудын нэгдмэл байдлыг хангах үүднээс холбогдох Яам, агентлагуудын удирдах албан тушаалтнуудтай нэ даруй зөвлөлдөх
- Төслийн шалгуур, урьдчилан тооцоолсон нөлөөлөл, нүүлгэн шилжүүлэлтэд үзүүлэх туслалцааны шалгуур болон эрх элдэхэд тасалбар болгох өдөр зэргийг тайлбарласан төслийн мэдээллийн

товхимол (ТМТ)-ыг Монгол болон Англи хэлээр (ХВ15-р бүлгийн шаардлагатай мэдээллийг танилцуулсан Хэрэгсэл 7-г үзнэ үү) бэлтгэх

- Мэдэгдэж буй нөлөөллийн нутаг дэвсгэрт ТМТ-ыг хэвлэн гаргах замаар нийтэд төслийн талаар танилцуулах
- Нийгэм, эдийн засгийн судалгаа ба өртсөн хүмүүс болон үл хөдлөх хөрөнгийн тооллого (ХВ15-р хэсгийг үзнэ үү. Хэрэгсэл 2 Хүн амын судалгаа ба хөрөнгийн тооллогын агуулга, Хэрэгсэл 3 Өртсөн хүн амын тойм тооллогын загвар, Хэрэгсэл 4 Өртсөн үл хөдлөх хөрөнгийн тойм тооллогын загвар, Хэрэгсэл 5 Өртсөн газрын тойм хуваарийн загвар).
- Нөлөөллийн байдлын зэрэг болон нөхөн олговор шаардлагатай эсэхийг тодорхой болгох, эзэмшигч/ашиглагч нь зөвшөөрч буй тохиолдолд сайн дурын газрын гэрээг бэлтгэх preparation (В5 хэсэг дэх журам болон В15 хэсгийн Хэрэгсэл 1-ийн зөвшөөрлийн загвар жишээг үзнэ үү).
- ӨИ-ийн мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн тооллого, эрхийн матриксийн төсөл (тухайн дэд төслийн нөлөөлөлд тааруулан шинэчилсэн ба энэхүү БОНУХ-ны ХВ15 Хэрэгсэл 6-д үзүүлсэн эрхийн матрикстай нийцсэн байх) болон албадан нөлөөллийг хамрах НШТ-ний төсвийг бэлтгэх.
- НШТ-ний төслийг Дэлхийн Банкны Үйл ажиллагааны бодлого 4.12. Албадан нүүлгэн шилжүүлэлт, Хавсралт А-гийн 1-21 дүгээр зүйлд нийцүүлэн бэлтгэх. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний тоймыг бүлэг В15-ын хэрэгсэл 9-д үзүүлэв.
- НШТ-ний төслийн мэдээлэл болон шинэчилсэн ТМТ-ыг олон нийтэд ил болгох.
- НШТ-г эцэслэх; тус НШТ-г зээлдэгч ба Дэлхийн Банкнаас батлах.
- Тус НШТ-г зээлдэгч болон Дэлхийн Банкны цахим хуудсанд байршуулах.
- Төлбөр олгох хэмжээ, удаа ба газрыг тодорхой заан, ӨИ тус бүрт нөхөн олгово ба эдлэх эрхийн маягтийг бэлтгэх.
- Зээлсэн ямарваа газрыг нөхөн сэргээх; эрх шилжүүлэх ба ӨИ-ийг чөлөөлөх.
- Бүртгэл хөтлөх ба донор болон санхүүжүүлэгч нарт тогтмол тайлагнах.
- ӨИ ба орон нутгийн иргэдийн оролцоотойгоор хяналт тавих ба үр дүнг нийтлэх.

Төсөл батлагдсны дараагаар урьдчилж тооцоолоогүй ямар нэгэн нөлөөлөл тодорхой болсон тохиолдолд НШТ-г шинэчлэн бэлтгэх ба олон нийттэй зөвлөлдөн, ил болгоно. Энэхүү НШБХ-нд заасан ижил зарчим, үйл ажиллагаа суурилсан НШТТ нь зохистой гэж үзвэл төслийн нэмэлт дэд бүрэлдэхүүн хэсгүүдийг хамарч болно.

Дэлхийн Банк нь ямарваа боловсруулсан нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (үүд)-ийг хянан, зөвшөөрөл олгоно.

## B 7. Хүн амын нүүлгэн шилжүүлэх тооцоо

*Бүрэлдэхүүн хэсэг 1 (Түгээх сүлжээ)*

Бүрэлдэхүүн хэсэг 1 дэх дэд төслүүдийн аль нэгнээс ямар нэгэн биет нүүлгэн шилжүүлэлт эсвэл ноцтой сөрөг нөлөөлөл үүснэ гэж урьдчилан тооцоолоогүй болно. Шугамын шинэчлэл болон 6-10/ 0.4 КВ-ийн дэд станцийг сэргээн засах үйл ажиллагаа нь одоо ашиглагдаж буй сүлжээний нутаг дэвсгэр болон дамжин өнгөрөх эрхийн хүрээнд явагдана. Эдгээр бага хэмжээний барилгын ажлын үеэр дуу чимээ, тоос болон замын хөдөлгөөний тасалдал зэргээс үүсэх түр хугацааны нөлөөллүүд байж болзошгүй ба эдгээрийг Хавсралт Б-д авч үзсэн болно.

Зарим шинэ газар 35/ 6-10кв-ийн станцийг сэргээн засахад шаардлагатай болж магадгүй юм. Одоо ашиглагдаж буй газрын оролцоох төрийн эзэмшлийн буюу түрээсийн газрыг эхлээд эрэлхийлэх болно. Энэ тохиолдолд ТУН-ээс тухайн газар нь үнэхээр төрийн эзэмшлийн/түрээсийнх бөгөөд ямар нэгэн албан ба албан бус суурьшил, шийдвэрлэгдээгүй гомдол байхгүйг баталгаажуулна. Хэрэв төрийн эзэмшлийн газар ашиглах боломжгүй бол амьжиргаа буюу нийгмийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөлөл нь хамгийн бага байх өөр бусад газрыг сонгоно.

*Бүрэлдэхүүн хэсэг 2 (Нарны цахилгаан станц)*
Аливаа ирээдүйн нарны эрчим хүчний хөрөнгө оруулалтанд ашиглагдаагүй төрийн эзэмшлийн газрыг айл өрхүүдэд нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэхийн тулд нэн тэргүүнд авч үзнэ. Эдгээр бага хэмжээний барилгын ажлын үеэр дуу чимээ, тоос болон замын хөдөлгөөний тасалдал зэргээс үүсэх түр хугацааны нөлөөллүүд байж болзошгүй ба эдгээрийг энэхүү БОНУХ-ний Хавсралт Б-д авч үзсэн болно.

Аливаа ирээдүйн нарны эрчим хүчний хөрөнгө оруулалтанд зориулан төрийн эзэмшлийн эсвэл түрээсийн газрыг эхлээд эрэлхийлэх болно. Энэ тохиолдолд ТУН-ээс тухайн газар нь үнэхээр төрийн эзэмшлийн/түрээсийнх бөгөөд ямар нэгэн албан ба албан бус суурьшил, шийдвэрлэгдээгүй гомдол байхгүйг баталгаажуулна. Хэрэв төрийн эзэмшлийн газар ашиглах боломжгүй бол амьжиргаа буюу нийгмийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөлөл нь хамгийн бага байх өөр бусад газрыг сонгоно. Албадан нүүлгэн шилжүүлэлт шаардлагатай тохиолдолд энэхүү НШБХ-нд тусгасан үйл ажиллагааг баримтлана.

## В 8. Эрх үүсэх шалгуур

Төсөлтэй хамаатуулан нүүлгэн шилжүүлэх хүмүүсийн ангилалд урьдчилан тооцогдож буй хүмүүст:

- Төрийн эзэмшил буй түрээсийн бус бөгөөд шаардлагатай ямарваа газар буюу газарт суурилсан үл хөдлөх хөрөнгийн эзэмшигч буюу ашиглагч.
- Барилга угсралтын түр хугацааны нөлөөлөлд автаж болзошгүй хөрш байрлах иргэд тус орно.

Эрх үүсэх шалгуур нь өртсөн хүн болон өртсөн үл хөдлөх хөрөнгийн аль алинд үйлчилнэ. Нүүлгэн шилжүүлэх хүмүүсийг дараах гурван бүлгийн нэгт хамаатуулан ангилах боломжтой юм. Үүнд: (a) тухайн газарт албан ёсны хуулийн дагуух эзэмшлийн эрх бүхий хүмүүс (тус улсын хууль тогтоомжийн хүлээн зөвшөөрсөн уламжлалт болон ёс заншлын эзэмшлийн эрхийг оролцуулна); (b) хүн амын тооллого эхлэхэд үед тухайн газарт албан ёсны хуулийн дагуух эзэмшлийн эрх байхгүй боловч уг газар буюу хөрөнгөд тус улсын хууль тогтоомжын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд заасан процессоор хүлээн зөвшөөрөгдсөн эзэмшил бүхий хүмүүс; (c) оршин сууж буй газартаа хүүлийн дагуу эзэмшлийн эрх буюу эзэмшил байхгүй хүмүүс.

Тэмдэглэл: (1) Алдагдал нь түр хугацааны болон байнгын байж болно; (2) нүүлгэн шилжүүлэлтийн туслалцаа гэдэг нь газрын эздэд алдагдсан газар, барилга, ургац зэрэгт олгосон нөхөн олговор гэсэн үг биш юм. Нүүлгэн шилжүүлэлтийн туслалцаа нь нүүх зардал эсвэл шинээр суурьших нутагтаа газраа бэлтгэх гэх мэт шинэ амьжиргаа эхлүүлэх зардал байж болно.

Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт нь өртсөн иргэд алдах хөрөнгөө орлуулах болон орлого, амьжиргааны түвшингээ сайжруулах эсвэл дор хаяж хуучин байдал нь нөхөн сэргээх хангалттай боломжтой байлгана. Цаашлаад, төлөвлөлт нь хүйс, нийгмийн байдал, хэл болон бусад шалгуураас шалтгаалан ямарваа өртсөн хүмүүсийг ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхахгүй байхыг хариуцна. Дээрх зорилтуудад хүрэхийн тулд ТУН нь бүх өртсөн хүмүүс тогтоогдон, тухайн НШТ-д тусгасан нөлөөлөл бууруулах зохих арга хэмжээнд хамрагдах эрхтэй байхыг хариуцна.

Түр хугацааны эсвэл байнгын эсэхээс үл хамааран төслийн нөлөөллөөр үүссэн, хүлээн зөвшөөрөх газар бус үл хөдлөх хөрөнгийн алдагдалд:

- Хувь хүний бизнес эсвэл орлого
- Олон нийтэд мэдээлэх болон зөвлөлдөх явцад илэрч болзошгүй Монгол Улсын хууль болон Дэлхийн Банкны үйл ажиллагааны бодлогоор хүлээн зөвшөөрөгдсөн ямарваа бусад хөрөнгө эсвэл амьжиргааны бүрэлдэхүүн хэсгүүд орно.

Эрхийн эдлэхэд тасалбар болох хугацаанд эдгээр шалтгааны аль нэгнээс сайн дурын бус алдагдлыг хүлээхээ батласан хүмүүсийг нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдах эрхтэй гэж үзнэ. Тухайн төслийн тасалбар болох хугацааны дараагаар эхэлсэн үйл ажиллагаа эсвэл зөрчлөөс үүдэх алдагдал нь хүлээн зөвшөөрөгдөхгүй.

## В 9. Үнэлгээний аргачлал

“Орлуулах өртөг” гэдэг нь алдсан хөрөнгийг орлуулан, шилжүүлгийн зардлыг хамруулахад хангалттай мөнгөн дүнг тодорхойлоход тустай хөрөнгө үнэлгээний арга юм. Энэхүү үнэлгээний аргачлалыг ашиглахад барилга, байгууламж болон хөрөнгийн элэгдлийг тооцохгүй байвал зохино. Мөнгөн дүнгээр нөхөн олговор тооцох буюу үнэлэхэд хялбар бус алдагдлын хувьд (жишээлбэл, төрийн үйлчилгээ, хэрэглэгч мөн нийлүүлэгчид буюу загасчлах, мал бэлчүүлэх эсвэл ойн модод ойр байх), адилтгах бөгөөд соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдөх байгалийн нөөц баялаг, орлого олох боломжид ойр байдлыг бий болгох оролдлого хийнэ.

НШТ-нд тусгахын тулд олон нийтийн зөвлөлдөх хэлэлцүүлгийн явцад өртсөн үл хөдлөх хөрөнгө ба үнэт зүйлсийг бүрэн тодорхойлно. Адил зүйлээр орлуулах, алдагдсан хөрөнгө болон орлогыг орлуулах зардал, амьжиргааг бүрэн нөхөн сэргээх зэрэг зарчмуудыг НШТ-нд ашиглана.

Бүх өртсөн хөрөнгүүдэд үнэлгээний багийнхны ижил төстэй хөрөнгийн зах зээлийн үнийг харьцуулан тооцсон орлуулах өртгийн дагуу нөхөн төлбөр олгоно. Үнэлгээний баг нь дараах бүрэлдэхүүнтэй байна: нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн; аймаг/сумдын газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (ГХБХБГ) ба өмчийн харилцааны газрын үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний мэргэжилтэнгүүд ба; өртсөн ААН-ийн болон өртсөн хүмүүстэй тохиролцсон төлөөлөгч байна. ТУН нь газар болон газар бус хөрөнгө ба алдагдлын нөхөн олговорын өртгийг үнэлэх үйл явцын мөрөөр арга хэмжээ авах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. ӨИ-тэй хэлэлцээ хийх явцад нөхөн олговорын хувь хэмжээ дээр саналын зөрүү гарсан тохиолдолд ТУН нь хараат бус хувийн үнэлгээний мэргэжилтэн хөлсөлж, ӨИ-д санал болгосон нөхөн төлбөрийн хувь хэмжээг дахин үнэлэх бөгөөд үр дүнг тэдгээрт танилцуулна.

Ирээдүйн дэд төслүүдэд хамаарах төрөл бүрийн болзошгүй нөлөөллүүдэд зориулсан аргачлалыг дор дурдав:

**Газар.** Өртсөн газарт орлуулах үнээр нөхөн төлбөр өгнө. Үнийг тодорхойлохдоо зах зээлийн зонхилох үнэ (газрын байршил, бизнесийн давуу тал, холбогдох боломж, мөн ангилал/газар ашиглалтын зориулалт, хөрсний төрөл, ургуулсан ургац, усалгаа ба бусад байгууламжаас гадна зам руу харсан, хөгжүүлсэн бүстэй ойр байдал, зохистой хэлбэр, тэгш газар зэрэг бусад давуу болон сул талууд гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлдөг)-ийг зах зээлийн судалгаа хийн, тодорхой болгосон үнэ эсвэл хүчин төгөлдөр үйлчилж буй төрийн нөхөн олговрын үнийн аль их нь байна. Өөр нэг хувилбар нь адилтгах орлуулах газрын үнэлгээ болно.

**Барилга, байшин ба байгууламж.** Эдгээрт элэгдэл, шилжүүлгийн зардал болон өртсөн өрхүүд үнэгүй ашиглах боломжтой үлдэгдэл материалын үнийг тооцохгүйгээр адилтгах төрлийн барилга, байгууламжийн зах зээлийн зонхилох үнэд тулгуурлан орлуулах үнээр нөхөн олговор олгоно.

**Түр хугацааны бизнесийн алдагдал.** Албан татварын баримт/бусад хүчин төгөлдөр баримт бичиг эсвэл эдгээр байхгүй бол төслийн бүс дэх замын нийтлэг бизнесийн татварын дараах дундаж орлогод суурилан тооцсон гэрээнд тусгагдах тасалдах хугацааны цэвэр орлогын алдагдалтай тэнцэх мөнгөн нөхөн олговор.

**Мод.** Модны ээлхүүнд суурилсан мөнгөн нөхөн олговор; жимсний модны хувьд орлуулах модны адилтгах үйлдвэрлэлийн түвшинд хүрэх жилүүдэд тухайн модноос олох жилийн дундаж цэвэр орлого болон орлуулах модыг ургуулах зардал (жишээлбэл, үрслүүлэх ба ургуулах) суурилна.

**Ургац алдах.** Хураасан ургацын зах зээлийн үнээр нөхөн олговор олгоно.

## В 10. Хэрэгжилтийн явц

Шударга байдлыг хадгалахын тулд дэд төсөлд зориулж бэлтгэсэн НШТ бүрт газар чөлөөлөлт ба нөхөн олговрын төлөлттэй холбоотой бүх үйл ажиллагааны цаг хугацааны хязгаартай хэрэгжүүлэлтийн хуваарийг оруулсан байна. Өртсөн хүнд барилгын ажил эхлэхээс өмнө мөн идээших цаг хугацаа олгохын тулд газар чөлөөлөхөөс дор хаяж нэг сарын өмнө нөхөн олговрын төлбөрийг хийсэн байвал зохино. Хэрэв газар эсвэл үл хөрөнгийн үнэлгээ ба нөхөн олговор төлөлтийн хооронд 1 жил болон түүнээс дээш хугацааны хойшлолт үүсвэл нөхөн олговрын хувь хэмжээг шаардлагатай инфляц, бусад зардлын хүчин зүйлсийг тооцсоны үндсэн дээр хянан шалгаж, өөрчлөнө. Хэлэлцэн тохирсон боловч эзэмшигчийг олоход хүндрэлтэй зэрэг үндэслэлтэйгээр төлбөр төлөлт хойшлох юм бол нөхөн олговрыг аль болох хурдан олгож болохоор Засгийн газрын эскроу дансанд байршуулж болно. Нөхөн олговроос хуримтлагдсан аливаа хүүг хууль ёсны нэхэмжлэгчдэд төлөх эсвэл хувааж өгнө. Энэ нь өмчийн эзэнд хохиролгүйгээр төслийн ажлыг үргэлжлүүлэх боломжийг олгоно.

## В 11. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн зөвлөлдөх хэлэлцүүлэг ба олон нийтэд мэдээлэх тогтолцоо

Тус БОНУХ-ний 6-р бүлэгт төслийн бүх үйл ажиллагааны зөвлөлдөх хэлэлцүүлэг ба оролцоог авч үзсэн болохоор энэ хэсэгт зөвлөлдөх хэлэлцүүлэг/олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг албадан нүүлгэн шилжүүлэлт талаас тусгайлан авч үзэх болно. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлтийн үе шатанд хийгдэх гол хэлэлцүүлгийн арга хэмжээг дурдвал: гол институцийн ба бизнесийн мэдээлэгчидтэй уулзалт хийх; ТМТ боловсруулах ба түгээх; ӨИ-ийг тодорхойлон нийгэм, эдийн засгийн судалгаа авах; албадан нүүлгэн шижлүүлэлтийн гомдол хүлээн авах механизмийг бий болгох; НШТ-ийн төслийг хэрхэн оролцох ба нөхөн төлбөр эрэлхийх мэдээлэлтэйгээр олон нийтэд ил болгох. Санал болгосон чөлөөлөх газар ба бусад зүйлсийн талаар аливаа өртсөн хүмүүстэй шууд зөвлөлдөнө.

Төлөвлөлтийн үе шатны гол баримт нь цаашид зохион байгуулах зөвлөлдөх үйл ажиллагааг оруулсан гүйцэтгэсэн үйл ажиллагаа ба зөвөлгөөний үр дүнг тоймлосон тохиролцсон НШТ байна. Бусад баримт нь олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчдын гарын үсэг зурсан бүртгэл, бүх зөвлөлдөх хэлэлцүүлэгийн үеэр яригдсан яриа ба шийдвэрийн тойм байх болно.

ТУН нь ТХН-үүдтэй хамтран өртсөн хүмүүс ба төсөл хамрах орон нутгийн ард иргэдэд НШТ-ийн төсөл ба эцсийн хувилбарыг өөрийн вэб сайт гаргах болон хэвлэмэл хувилбарыг эх хэл дээр нь, авч үзэхэд хялбар байршилд хүргэх байдлаар танилцуулна. Энэ болон бусад Банктай хамтарч хийх ирээдүйн төслүүдэд НШТ-ийн төслийг Банкны хяналтаас дор хаяж нэг сарын өмнө олон нийтэд мэдээлнэ. Банкнаас зөвшөөрсөний дараагаар НШТ-ийн эцсийн хувилбарыг олон нийтэд хүргэнэ.

## В 12. Газар чөлөөлөхтэй холбоотой гомдлын журам

Төсөлд мөрдөх гомдлын журмыг боловсруулсан ямарваа Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд нэгэн адил үйлчлэх БОНУХ-ын гомдол шийдвэрлэх тогтолцооны тухай 8-р бүлэгт тайлбарласан байгаа (доорхийг үзнэ үү). Томоохон гомдол гаргахгүйн тулд хувийн эзэмшлийн газрын хэрэгцээг хамгийн бага түвшинд байлгах буюу зайлсхийх байдлаар дэд төслийг загварчилах ба аливаа нөлөөллийн хэмжээг бага байна гэж тооцоолж буйг харгалзан төсөлд зориулан бий болсон орон нутгийн гомдол шийдвэрлэх тогтолцоог ашиглахыг дэмжинэ.

Гомдлын шийдвэрлэх процесс нь тухайн гомдлын цар хүрээнд тохируулан арга хэмжээг санал болгоно. Уг процесс нь дараах байдлаар явагдана:

- Хэвийн ажлын үйл ажиллагааны үеэр гүйцэтгэгчид буюу БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) -ний албан хаагчдын шийдвэрлэх боломжтой санал, гомдлыг нэн даруй шийдвэрлэнэ. Тус гомдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (юу, хэзээ, огноо, өдрийн цаг, хүйс, бусад ажиглалтууд), гомдол мэдүүлэгчийн холбоо барих мэдээлэл, арга хэмжээ/хэмжээнүүд болон хаасан

огноо зэргийг тэмдэглэнэ. Гомдлыг утсаар, шуудан, цахим шуудангаар БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) рүү эсвэл БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) рүү гомдлыг уламжлах сумын төлөөлөгчид биеэр гаргах боломжтой.

- Нэн даруй буюу гүйцэтгэгч, БЗӨБЦТС/ЭБЦТС (Бүрэлдэхүүн хэсэг 1) буюу ББЭХС (Бүрэлдэхүүн хэсэг 2) -ний албан хаагчдын шийдвэрлэх боломжгүй төсөлтэй холбоотой бусад гомдлыг боломжтой бол ажлын арван таван өдөрт багтаан богино хугацаанд зуучлуулахаар ТУН-ийн хамгааллын мэргэжилтэнд эхлээд мэдэгдэнэ. ТУН-ийн хамгааллын мэргэжилтэн нь өртсөн хүн (хүмүүс) буюу өртсөн бүлгийн оршин суугаа газартай ойр газар нээлттэй зөвөлгөөнд гомдолтой холбогдох этгээдүүд болон гомдол мэдүүлэгчийг оролцуулан зуучлах сонсголыг зохион байгуулна. Гомдол мэдүүлэгч нь тус явцад дэмжигчидын хамт оролцохыг дэмжинэ.
- Хэрэв зуучлалын үйл ажиллагаа амжилтгүй болвол эсхүл уг асуудал нь үндэслэлтэй бол өртсөн этгээд нь аль ч хугацаанд Монгол Улсын хууль тогтоомж, журамд нийцүүлэн Монголын шүүх тогтолцоогоор дамжуулан бичгэн буюу аман гомдол гаргаж болно.

Ямар ч үед төслийн гомдол шийдвэрлэх тогтолцоо тухайн санал, гомдлыг шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзвэл Дэлхийн Банкны гомдол шийдвэрлэх үйлчилгээ болон Дэлхийн Банкны Хяналт шалгалтын комисст хандах боломжтой юм. Дэлхийн Банкны Гомдол шийдвэрлэх үйлчилгээ (ГШҮ)-нд гомдол хэрхэн мэдүүлэх тухай мэдээллийг http://www.worldbank.org/GRS хаягаар үзэж болно. Дэлхийн Банкны Хяналт шалтгалтын комисст гомдол хэрхэн мэдүүлэх тухай мэдээллийг www.inspectionpanel.org хаягаар үзэж болно.

## В 13. Санхүүжилтын тогтолцоо

Төслийг хэрэгжүүлэгч/Банкнаас зээлдэгч нь газар чөлөөлөхтэй холбоотой зардал гаргахыг хариуцна. Энэ НШБХ-ний дагуу бэлдсэн НШТ тус бүр НШТ-г хэрэгжүүлэхтэй холбоотой бүх үйл ажиллагааны зардлыг тооцоолсон төсөвтэй байх шаардлагатай. Өртсөн газар ба өмч хөрөнгийн тооллогыг хийхэд бүх өртсөн хүнийг оруулах ёстой боловч хэрэв хүн амын тооллого хийж эхлэх үед хууль ёсны эрхтэй хүнийг алдаа гарган орхигдуулсан тохиолдолд нүүлгэн шилжүүлэлт төлөвлөлтийн дараа тодорхой болвол нөлөөлөл бууруулах үйл ажиллагааны эхний санхүүжилтын мөнгө хангалтгүй хуваарилагдсан байсан ч гэсэн тухайн хүнд нөхөн олговор олгоно. Иймэрхүү болон бусад урьдчилан тооцоолоогүй гарч болох зардлыг гаргахын тулд НШТ-ийн төсөвт тооцоолсон нийт зардлын 10 хувьтай тэнцэх нөөц сан байгуулсан байна. Олгох нөхөн олговрын хэмжээг НШТ-д оруулсан нөхөн олговрын хувь хэмжээнд дээр тулгуурлан тооцоолно. Ямар нэгэн барилгын ажил эхлэхээс өмнө өртсөн болон газар, бусад үл хөдлөх хөрөнгө, орлогоо алдсан хүмүүст нөхөн олговрыг бүрэн болгоно.

Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлтийн төсөв нь дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:

Захиргааны зардал:

- Хамгааллын ажилтнуудын цалингийн зардал/хэрэв гаднаас ТББ/зөвлөх томилогдох юм бол зөвлөх үйлчилгээний хөлс.
- Оффисийн зардал, тоног төхөөрөмж ашиглах, хангамж.
- Замын зардал.
- Зар сурталчилгаа ба хэвлэл.

Нүүлгэн шилжүүлэлтийн зардал:

- ӨИ-тэй зөвлөлдөх уулзалтын зардал (замын зардал/ зуучлалын хөлс).

Нөхөн олговрын зардал:

- Өртсөн зүйлст дараах орно:
  - o Газар.
  - o Өртсөн үл хөдлөх хөрөнгө ба амьжиргаа.

o Нүүлгэн шилжүүлэх ба дахин суурьшихад үзүүлэх тусламж.

• Гүйлгээний зардал (нотариатын хураамж, кадастрын зургийн үйлчилгээ, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг оруулсан үйлчилгээний хураамжууд).

• Дээрхийн нийлбэр дүнгийн 10 хувьтай тэнцэх өртөмхий байдал ба урьдчилан тооцоолоогүй зардалд зориулсан болзошгүй байдлын зардал.

• Эрхийн тусламжийг олгох комиссийн гишүүний зардал.

Нөхөн төлбөрөөс ямар ч шалтгааны улмаас хасалт хийж болохгүй. НШТ нь ЭХЯ-наас өртсөн хүмүүст нөхөн олговор олгох санхүүжилтын урсгал ба гүйлгээг гэрчлэх, бүртгэхэд зориулсан ил тод процедурийг бий болгоно. Айл бүрээс нөхөр ба эхнэр хоёрын хоёулаа хамтдаа гарын үсэг зурж (нөхөн олговор) авахыг дэмжих болно.

## B 14 Албадан нүүлгэн шилжүүлэлтэнд тавих хяналт

6-р бүлэгт БОНУХ-ний хяналт тавих шаардлагыг бүрэн тоймлон үзүүлсэн ба энэ хэсэг нь НШТ-нд багтах хяналт тавих шаардлагуудтай холбоотой болно. Хяналт тавих нь зээлдэгчийн хариуцах үйл ажиллагаа бөгөөд дотоод (эсвэл төслийн удирдлага) ба гадаад (эсвэл хөндлөнгийн) хяналт гэж хуваагдана. Хэрэгжилтийн явцад НШТ-д нийцэж буйд тавих хяналтыг ТУН-аас гадна дотоодын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компани, ТББ, шаардлага хангасан хувь хүн байж болох хөндлөнгийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ. НШТ тус бүрт дотоод ба гадаад хяналтын шалгуур үзүүлэлтүүдийг тусгана.

ТУН нь ТНХ-тэй хамтран Дэлхийн банктай байгуулсан зээлдэгчийн гэрээнд тодорхойлсон аливаа шалгуур үзүүлэлтүүдийн дагуу НШТ-ийн тогтмол явцын тайланг бэлтгэхийн хамт хяналт тавьсан хугацаанд хамааруулан дараах зүйлсийг оруулна. Үүнд:

- Бодлогын зорилтонд хүрэхийн тулд НШТ-нд өөрчлөлт оруулах шаардлага үүсгэн аливаа асуудал.
- Нүүлгэн шилжүүлэлтийн процессийн талаарх ТМТ ба аливаа хэвлэл мэдээллийн мэдээ зэрэг олон нийтэд хүрсэн мэдээлэл.
- НӨИ-тэй хийх зөвлөлдөх хэлэлцүүлгийн хуваарь.
- НШТ-ийн зөвлөлдөх уулзалтанд оролцсон оролцогчдын гарын үсэг бүхий ирц, зураг, ямар нэгэн оролцоог батлах бусад баримтууд.
- НШТ-ийн хэлэлцүүлэг ба шийдвэрийн тойм тэмдэглэл.
- ШТ-ийн явцад тэмдэглэгдсэн гомдлын бүртгэл, процесс ба үр дүн.
- Төсөлтэй холбоотой газар ашиглалтын өөрчлөлт эсвэл газрын эрх шилжүүлэх албан ёсны бүртгэлийн хуулбар.
- Сайн дурын газар хандивлалт эсвэл шилжүүлгийн бүртгэл ба НШТ-ийн хүрээнд үүссэн эрхийн дагуух төлбөрийн явцыг харуулсан Эрхийн матриксийн шинэчилсэн мэдээ.
- Эрхийн дагуу олгосон төлбөрийн санхүүгийн тойм.

## В 15. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн хэрэгслийн багц

**Хэрэгсэл 1: Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн зөвшөөрлийн загвар форм (Сайн дурын хандивлалт)**

Огноо: ____________________________

Би/Бид:_____________________ өрх толгойлсон эрэгтэй____________________өрх толгойлсон эмэгтэй.

